

2014 оны Хуваалцах цагийн тойм

Гэр Бүлүүд Үүрд Хамт Байх Болно

“Тэрээр эцгүүдийн зүрхийг хүүхдүүд уруу нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлнэ” (Малахи 4:6).





Хуваалцах цаг болон Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгын удирдамж

Хүндэт Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийнхөн болон Хөгжмийн Удирдагчид аа

Энэ жил бидэнд Хүүхдийн хэсгийн хүүхэд бүрд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх гэр бүлүүдийн ач холбогдлыг ойлгоход нь туслах гайхалтай боломж тохиож байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас томилогддогийг, гэр бүл бол Түүний төлөвлөгөөний гол цөм мөн ариун сүмийн нандин ёслолуудаар дамжуулан гэр бүлүүд үүрд хамтдаа байж чадна гэдгийг хүүхдүүд сурах болно. Хуваалцах цагийн хичээлүүд нь хүүхдүүдийн гэртээ сурч мөн хэрэгжүүлдэг зарчмуудыг дэмждэг. Хүүхдүүдийн суралцдаг сургаалууд нь одоо гэр бүлүүдийг нь бэхжүүлж, ирээдүйд итгэлтэй аав ээж болохоор бэлтгэхэд нь тусалдаг. Та долоо хоног тутам залбирч бэлтгэж мөн Сүнсийг урьснаар хүүхдүүдийн зүрх сэтгэлд сайн мэдээний үнэнийг баглах болно. Хүүхдүүдийг Хүүхдийн Хэсэгт сурч мөн мэдрсэн зүйлсээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцуулах боломжийг эрж хай.

Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн бид та бүхний төлөө залбирдаг бөгөөд энэхүү чухал үүрэг хариуцлагад тань Их Эзэн та нарт тусална гэдгийг мэднэ. Та бүхний хүүхдүүдэд болон тэдний гэр бүлүүдэд зааж мөн үйлчлэх шаргуу хичээл зүтгэл тань тэднийг хүчирхэгжүүлэх болно. Бид та бүхний итгэлтэй үйлчлэлд агуу хайр хийгээд талархлаа илэрхийлж байна.

Хүүхдийн Хэсгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөл

Хуваалцах цагийн зааварчилгаа

Сайн мэдээний зааварчилгаа

Долоо хоног тутам заагдах хуваалцах цагийн 15 минутын хичээлийг бэлтгэхдээ энэхүү товхимлыг ашиглана уу. Та сүмээс зөвшөөрөгдсөн *Найз эсвэл Лиахона зэрэг бусад материалуудыг ашиглаж болно.* Дараах удирдамжууд хичээлээ төлөвлөж заахад тань тусална.

Заадаг хүүхдүүдэд хайрла. Хүүхдүүдийн нэрсийг мөн тэдний сонирхол, авьяас билэг, хэрэгцээ шаардлагыг мэддэг болсноор тэднийг хайрлагдгаа харуул.

Сургаалыг Сүнсээр заа. Хичээлээ бэлтгэх явцдаа заах зарчмуудынхаа талаар гэрчлэлээ бэхжүүлж, удирдамж хүлээн авахын төлөө залбир. Энэ нь Сүнсээр заахад тань тусална.

Суралцахад урь. Энэхүү товхимол нь зөвхөн юу заахыг хэлээд зогсохгүй, *хэрхэн* заах болон хүүхдүүдийг хичээлд идэвхтэй оролцуулахыг мэдэхэд тань тусалж чадна. Дараах гурван зүйлийг хичээл бүр дээр хэрэгжүүлснээр та сургаалыг илүү үр дүнтэйгээр зааж чадна.

Долоо хоног бүр (1) сургаалыг таньж мэдэх, (2) үүнийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах, (3) тэднийг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь дэмжих арга замуудыг төлөвлө.

1. Сургаалыг таньж мэд. Хүүхдүүдийн сурч байгаа сургаалыг ойлгомжтойгоор танилцуул.

Үүнийг хийхдээ хэл яриа болон үзүүлэнгийн арга замуудыг сонго. (Жишээ болгож Наймдугаар сарын гурав дахь болон Арваннэгдүгээр сарын хоёр дахь долоо хоногийн хичээлүүдийг үзнэ үү.)

2. Ойлголтыг нь урамшуулан дэмж. Дуулах, жүжигчилсэн тоглолт хийж үзүүлэх, судруудаас унших зэрэг тэднийг суралцахад урамшуулдаг олон янзын заах аргуудаар хүүхдүүдийг сургаалыг илүү гүнзгий ойлгоход анхаар.
3. Сургаалыг хэрэгжүүлэхэд урамшуул. Сургаалыг хэрэгжүүлэх боломжийг хүүхдүүдэд олго. Тэднийг тухайн сургаалтай холбоотой зорилго тавих эсвэл үүний талаарх мэдрэмжээ илэрхийлж сурахад нь анхаарал хандуул.

Энэ товхимолд энэ жилийн зарим долоо хоногуудад заагдах бүтэн хичээлийг багтаасан болно. Бусад долоо хоногуудад бүтэн хичээлүүдийг бус зөвхөн санаануудыг оруулж өгсөн байгаа. Эдгээр санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Та энэхүү товхимолд багтсан бусад хичээлийг

уншиж судлан, санаа авах боломжтой. Тав дахь ням гарагт өмнө үзсэн хичээлүүдээ бататган

Интернетээс олж үзэх боломжтой

Зүйлс: Энэ гарын авлагад дурдсан мэдээлэл, үзүүлэн, эш татсан эх сурвалжуудыг интернетэд LDS.org хуудасны Хүүхдийн хэсэг-ээс олж үзэх боломжтой.

давтаж болно. Хичээлд зориулсан үйл ажиллагаануудыг төлөвлөж, бэлтгэх үед Сүнс таныг удирдан хөтөлнө.

Хичээлээ бэлтгэхдээ хөгжмийн удирдагчтай хамтран ажилла. Дуу дуулах нь таны зааж буй сургаалыг тодотгож, баяжуулахад тань тусална. Та зарим үед сайн мэдээний хэсгийг заахдаа өөр ангийн багш, хүүхдүүдийг хичээлд оролцохыг урьж болно.

Зарим хичээл дээр Хүүхдийн хэсэгт үг хэлэх зочдыг урихыг санал болгодог. Гэхдээ хэн нэгийг урихынхаа өмнө бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авах хэрэгтэй.


Заах ур чадвараа сайжруулахад тань туслах хэд хэдэн зөвлөгөө хичээлүүдэд орсон байгаа. Танд үйл ажиллагаануудыг ойлгомжтой болгоход туслахын тулд зургуудыг хичээлүүдэд хавсаргасан. Хэдийгээр заах ур чадвар чухал боловч таны өөрийн сүнслэг бэлтгэл, гэрчлэл нь

хүүхдүүдийн зүрх сэтгэлд эдгээр сургаалуудыг бататгаж өгөх Сүнсийг урьдаг билээ.

Дуу дуулах цаг

Хүүхдийн хэсгийн дуу хөгжим нь хүндэтгэл бишрэлтэй байх нам гүм орчинг бүрдүүлж, сайн мэдээг заадаг төдийгүй хүүхдүүдэд Ариун Сүнсний нөлөөг болон дуу дуулснаар ирдэг баяр баяслыг мэдрэхэд нь тусална. Хуваалцах цагийн 20 минутыг дуу дуулах болон шинэ дуу заахад зориулах хэрэгтэй. Энэ хугацаа нь шинэ дуу заах болон хүүхдүүд дуулснаар сайхан мэдрэмж хүлээн авах хангалттай цаг юм.

Энэхүү товхимолд энэ жил хүүхдүүдийн сурах ёстой шинэ дууг багтаасан (28–29-р хуудсыг үзнэ үү). Түүнчлэн “Хүүхдийн хэсэгт дуу хөгжим хэрхэн ашиглах тухай” гэсэн хэсгийг оруулж өгсөн бөгөөд үүндээ дуунуудыг хүүхдүүдэд заах нэмэлт санаануудыг багтаасан байгаа (26–27-р хуудсыг үзнэ үү).



Бэлтгэл: Хуваалцах цагаар заах бэлтгэлээ хангахдаа удирдамж болоод Сүнсний нөлөөг эрэлхийлэн залбир. Та Сүнсээр бэлтгэж, заахад Сүнс зааж буй зүйлсийг тань үнэн гэдгийг батлах болно. (TNGC, 13-ыг үзнэ үү.)

Ариун ёслолын цуглаан дээр хийх танилцуулгын удирдамж

Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгыг жилийн дөрөв дэх улиралд бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор хийдэг. Тухайн жилийн эхээр Хүүхдийн хэсгийг хариуцсан бишопын зөвлөл эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөлтэй уулзаж, урьдчилсан төлөвлөгөөний талаар ярилц. Төлөвлөгөөг гүйцэд хийсэн үедээ зөвшөөрөл ав.

Хүүхдийн хөтөлбөрийг сар тутмын хуваалцах цагийн сэдвүүдэд тулгуурлан төлөвлөсөн байх хэрэгтэй. Танилцуулгад ашиглах зорилгоор жилийн туршид хүүхдүүдийн хэлсэн үг, хувийн туршлагыг тэмдэглэн авч болно. Тухайн жилийн сэдвийн талаар сурсан зүйлээсээ

хүүхдүүдийг хуваалцахад цугларагсдыг тэдний зааж байгаа сайн мэдээний сургаалд анхаарал хандуулахад нь туслах арга замыг бодоорой. Бишопын зөвлөлийн нэг гишүүн товч дүгнэлтийг хэлж, цуглааныг хаана.

Танилцуулгыг бэлтгэх явцадаа дараах удирдамжуудыг баримтал.

- Танилцуулгад бэлтгэх бэлтгэл нь хичээл эсвэл гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагаас нь авахгүй байх ёстой.
- Үзүүлэнгийн материалууд, хувцас өмсгөл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэргийг ариун ёслолын цуглаанд ашиглах нь зохисгүй юм.



Энэхүү товхимолд ашигласан эх сурвалжууд

Тус товхимолд дараах товчлолуудыг хэрэглэсэн:

ХДН Хүүхдийн дууны ном

СМЗН Сайн мэдээний зургийн ном

TNGC Teaching, No Greater Call

Олон хичээлд зураг ашиглахыг зөвлөсөн байгаа. Та зургуудыг Сайн мэдээний уран зургийн ном, Хүүхдийн хэсгийн гарын авлагын зургийн цомгууд, Сүмийн сэтгүүл болон интернет дэх images.lds.org хаягаар орж авч болно.

2014 оны Сургалтын хөтөлбөр

Ерөнхий хөтөлбөр

Балчир хүүхдийн анги: Бяцхан үрсээ болгоогтун; Нарны цацраг: Хүүхдийн хэсэг 1; ЗС 4–7: Хүүхдийн хэсэг 2; Баатрууд 8–11: Хүүхдийн хэсэг 6

Үндсэн сургалтын хөтөлбөр

Нарны цацраг: Хүүхдийн хэсэг 1; ЗС 4–7: Хүүхдийн хэсэг 2; Баатрууд 8–11: Хүүхдийн хэсэг 4

Эх сурвалжууд: Та

будах хуудас, түүх, үйл ажиллагаанууд зэрэг нэмэлт эх сурвалжуудыг Найз, Лиакхона, Балчир хүүхдийн ангийн гарын авлага ба Сайн мэдээний уран зургийн номоос олж болно. Эдгээр эх сурвалжуудыг ашиглан, хичээлээ баяжуулан дэлгэрүүл. Мөн сайн мэдээний онцгой сэдвүүдээр өгөгдсөн эх сурвалжуудын жагсаалтыг friend.lds.org дахь Найз хэсгээс хараарай. Хүүхдүүдэд заахын тулд эдгээр эх сурвалжуудыг хэвлэн, ашиглаж болно.

Тэнгэрлэг Эцэг Өөрийнх нь оршихуйд буцаж очих замыг надад бэлтгэсэн

Дуу: “Тэр Хүүгээ илгээсэн”
(ХДН, 34–35)

Энэхүү тойм дахь дуунуудыг хэрхэн заахыг Хүүхдийн хэсэгт дуу хөгжим хэрхэн ашиглах тухай 26-27 дугаар хуудсанд дурдсан.

Оролцоход урь: Хүүхдүүд хичээлд идэвхтэй оролцох үедээ өөрсдийнхөө чухлыг мэдэрдэг. Боломжтой үед өөрөө хийхийн оронд хүүхдүүдийг урьж, самбарт бичүүл эсвэл судар уншуул.

“Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би тэднийг Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Би Бурханы хүүхэд ба хэзээ нэгэн цагт Түүнтэй адил болж чадна

Сургаалыг таньж мэдэн, ойлголтыг нь урамшуул (зургуудыг харах, дуу дуулах ба судраас унших): Амьтдын үр төлийн хэдэн зургийг хүүхдүүдэд үзүүлэн, тэд өсөж томроод ямар амьтад болдгийг асуу (Жишээ нь: Муурын зулзага өсөж томроод муур болно). Нялх хүүхдийн зураг үзүүлэн, ижил асуулт асуу. Амьтдын үр төлөөс ялгаатай нэгэн онцлог хүний үрд байдаг гэдгийг тайлбарла. “Би Бурханы хүүхэд” (ХДН, 2–3) дууллыг хамтдаа дуулахдаа бид хэний хүүхдүүд болохыг олж сонсоход хүүхдүүдийг урь. Нэг хүүхдээс Дуулал 82:6-г уншихыг хүс, тэгээд уг дуу болон судрын зааж буй зарчмыг хэлэлц. Самбар дээр “Би Бурханы хүүхэд ба хэзээ нэгэн

цагт Түүнтэй адил болж чадна” гэж бичээд үүнийг чангаар уншихыг нэг хүүхдээс хүс.

Сургаалыг хэрэгжүүлэхэд урамшуул (хуваалцах): Эцэг эхээсээ хайрыг мэдэрдэг арга замуудыг нь хуваалцуулахаар хэдэн хүүхдийг урь. Тэнгэрлэг Эцэг биднийг Өөрийнх нь хайрыг ч бас мэдрээсэй хэмээн хүсдэг гэдгийг тайлбарла. Бурханы хайрыг мэдэрдэг өөрийн арга замаа хуваалцан, Түүний хайрыг мэдэрдэг арга замуудаас нь хуваалцуулахаар хэдэн хүүхдийг урь. “Эцэг минь амьдыг би мэднэ” (ХДН, 5) дууллыг хамтдаа дуулах үедээ Түүний хайрын тухай бидэнд юу шивнэж буйг нь олж сонсохыг хүүхдүүдээс хүс.

Хоёрдугаар долоо хоног: Тэнгэрлэг Эцэг Аврагчийг илгээж, Түүний оршихуйд буцаж очихыг надад боломжтой болгосон

Ойлголтыг нь урамшуул (Цагаатгалын тухай ярилц): Самбар дээр шулуун зураасан зам зурж, төгсгөл хэсэгт нь “Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрах Мөнх Амьдрал” гэж бич. Уг замын эхлэл хэсэгт хүний зураг байрлуул. Энэхүү зураг нь биднийг төлөөлж байгаа бөгөөд Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очихын тулд бид энэ замыг дагах хэрэгтэй гэдгийг тайлбарла. Бид өөрсдөө Тэнгэрлэг Эцэг рүү буцаж очиж чадахгүй гэдгийг хүүхдүүдэд хэл. Зурсан замынхаа нэг хэсгийг арилгаад

“Биднийг энэ зам дээр үлдэхэд юу тусалж чадах вэ?” гэж асуу. Нэг хүүхдээс итгэлийн гурав дахь тунхгийг унших эсвэл цээжээр хэлэхийг хүс. Гетсеманийн цэцэрлэг дэх Христийн зургийг үзүүлэн, Цагаатгалыг товчхон тайлбарла. Христийн Цагаатгал нь биднийг Тэнгэрлэг Эцэг рүү буцаж очиход тусалж чадах гүүртэй адил бөгөөд хэрэв бид наманчилж мөн зарлигуудыг дуулгавартай дагавал Түүнтэй дахин хамт амьдарч чадна гэдгийг хүүхдүүдэд хэл. Самбар дээр гүүр зурж, хүний зургийг замын төгсгөл хүртэл явуул. Есүс Христ болон Түүний Цагаатгалын талаар сэтгэгдлийг нь хуваалцуулахаар хэдэн хүүхдийг урь. Хэрэв цаг үлдвэл “Би тэнгэрт амьдарч байсан” (ХДН, 4) дууллыг дуул.



Гуравдугаар долоо хоног: Есүс Христ бол миний дагах төгс үлгэр жишээ мөн

Сургаалыг таньж мэд (Жишээнүүдийг ярилцах): “Хэн бидэнд сайн үлгэр жишээ үзүүлсэн бэ?” гэж асуу. Есүс Христ гэсэн хариултыг бусад хариултуудтай хамт самбарт бичих юм уу нэг хүүхдээр бичүүл. Эдгээр бүх хүмүүс бидэнд сайн үлгэр жишээг үзүүлдэг, зөвхөн Есүс Христ төгс үлгэр жишээг үзүүлсэн гэдгийг тайлбарла. Тэрээр “сайныг үйлдэж явсан” (Үйлс 10:38) бөгөөд бусдад үйлчлэн хайраа харуулж мөн

биднийг Өөрийнх нь үлгэр жишээг дагаасай хэмээн хүсдэг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Ойлголтыг нь урамшуул (түүх сонсох ба зураг зурах): Хүүхдийн хэсэг эхлэхээс өмнө насанд хүрсэн дөрвөн хүнийг доорх зургууд болон түүхүүдийг тайлбарлаж, хэрхэн Есүс Христийн үлгэр жишээг дагаж чадах тухай товч ярихад бэлтгэхийг хүс.



Иохан 13:14–15



Матай 5:1–2



Лук 15:4



3 Нифай 17:1–10

Багш нар багахан бүлгийн ярилцлагыг удирдах, идэвхтэй оролцохыг урамшуулах мөн хүндэтгэл бишрэлтэй байдлыг хадгалахад нь тусалж чадна.

Хүүхдүүдийг дөрвөн бүлэг болгон хуваарилж, бүлэг тус бүрд нэг насанд хүрэгчийг томил. Уг насанд хүрэгчийн өгүүлэх Аврагчийн тухай яриаг сонсоод, тэд хэрхэн Есүсийн үлгэр жишээг дагаж чадахыг хуудас цаасан дээр зурах эсвэл бичихийг хүүхдүүдээс хүс. Бүлэг тус бүрээс нэг хүүхдийг урьж, сурсан зүйлээ бусадтайгаа хуваалцахад урь.

Сургаалыг хэрэгжүүлэхэд урамшуул (дуу дуулах): “Би Есүс шиг байхыг хичээнэ” (ХДН, 78–79) дууллыг дуул. Энэ долоо хоногт Есүсийн үлгэр жишээг дагаж, уг хийсэн зүйлээ дараачийн долоо хоногт ярихад бэлтгэхийг хүүхдүүдээс хүс.



Дөрөвдүгээр долоо хоног: Би Есүс Христийг дагаснаар Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиж чадна

Сургаалыг таньж мэд (давтах): Хоёрдугаар долоо хоногийн хичээл дээр зурсан замыг самбарт дахин зур. Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очихыг хэн боломжтой болгосныг тайлбарлахыг хүүхдүүдээс хүс. Хэдэн хүүхдээр өнгөрсөн долоо хоногийн турш тэд хэрхэн Христийн үлгэр жишээг дагасныг нь яриул. Тэднийг Есүсийг дагаж чадах (баптисм хүртэх, залбирах ба зарлигуудыг дуулгавартай дагах зэрэг) өөр арга замуудыг хуваалцахад нь урь. Хариултуудыг нь самбарт бич.

Ойлголтыг нь урамшуул (судрын түүх сонсох): Есүс Төлөөлөгчдөө дуудаж буй түүхийг ярьж (Матай 4:18–22-ыг үз), өөртэй чинь хамт үүнийг үйлдлээр үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Жишээ нь: “Петр, Андрей нар загас барьж амьдралаа залгуулдаг байжээ. Нэгэн өдөр тэд Галил нууранд тороо тавьж байхдаа (тор тавина) Назар хотын Есүсийг харав. Тэд түүний “Намайг дага” хэмээн хэлэхийг сонсжээ (гараа чихэн дээрээ тавина). Хэдийгээр Петр, Андрей нар ажлаа хийж байсан боловч (тороо татна), тэд нэн даруй тороо орхиж (тороо хаяна), Түүнийг дагав (алхаж явна). Иаков, Иохан нар өөр завин дотор тороо сэлбэж байлаа (тороо засна). Есүс тэднийг дуудахад тэд тороо орхиж Түүнийг дагав (алхаж явна).” Хэрэв Аврагч тэдэнд “Намайг дага” гэж хэлбэл тэд хийж байсан зүйлсээ орхих байсан эсэхийг хүүхдүүдээс асуу. Усанд сэлэх, тоглоом тоглох зэрэг үйл ажиллагаа хийж байгаагаар бусад хүүхдүүдийг жүжиглэхэд анги бүрээр удирдуул. “Намайг дага” хэмээх үгсийг сонсох үедээ хийж байгаа зүйлээ зогсоож, алхаж явахыг хүүхдүүдээс хүс. Тэд бүх үйлдлүүдийг жүжигчлэн тоглосны дараа Есүс Христийн зургийг өргөн харуулж “Намайг дага” хэмээн намуухнаар хэл.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (жишээнүүдийг ярилцах): Тэд өнөөдөр Есүс Христийг дагаж чадах арга замуудаасаа хуваалцахыг хүүхдүүдээс хүс. Жишээ нь: Тэд гэр бүлийн залбирал хийх эцэг эхийнхээ хүсэлтийг эсвэл хүндэтгэл бишрэлтэй байх багшийнхаа урилгыг хүлээн авч болно.

Зөвлөгөө: Хүүхдүүд Аврагчийг жүжгийн зохиолд оруулан дүрслэх ёсгүй.



Сүнсээр заа: Хуваалцах цагаар заах бэлтгэлээ хангахдаа удирдамж болоод Сүнсний нөлөөг эрэлхийлэн залбир. Та Сүнсээр бэлтгэж, заахад Сүнс зааж буй зүйлсийг тань үнэн гэдгийг батлах болно.



Тэнгэрлэг Эцэгт хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөө байдаг

Дуу: “Би Бурханы төлөвлөгөөг дагана” (ХДН, 164–165)

“Ай Бурханы маань төлөвлөгөө хичнээн агуу билээ!” (2 Нифай 9:13).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Тэнгэрлэг Эцэгт хүүхдүүддээ зориулсан төлөвлөгөө байдаг



Үзүүлэн: Хүүхдүүд харсан зүйлдээ сайн хариу үйлдэл үзүүлдэг. Биетэд зүйлс, самбар дээр зурсан зураг, үгийн хайлчилбарууд, зурагнууд, хуруугаа хийж хөдөлгөдөг хүүхэлдэй зэрэг олон төрлийн үзүүлэн таниулах материал ашиглах нь зүйтэй. (ТNGC, 89–90-ийг үзнэ үү).

Сургаалыг таньж мэд (сургаалыг хэлэх): Ангийн урд гурван хүүхэд гаргаж зогсоо. Эхний хүүхдээр “Тэнгэрлэг Эцэгт,” хоёр дахь хүүхдээр “хүүхдүүддээ зориулсан,” гурав дахь хүүхдээр “төлөвлөгөө байдаг” гэж хэлүүл. Хүүхдүүдийг гурван бүлэг болгон хуваарилж, бүлэг тус бүрийг босож зогсон, тэдгээр гурван хүүхдээр удирдуулж, уг өгүүлбэрийн хэсгүүдийг давтан хэлэхийг хүс. Бүлэг тус бүрд өгүүлбэрийн хэсэг болгоныг хэлэх боломжийг олгож, хэд хэдэн удаа хэлүүл.

Ойлголтыг нь урамшуул (судруудыг унших): Бид төрөхөөсөө өмнө тэнгэрлэг эцэг эхийнхээ хамт тэнгэрт амьдарч байсан гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг биднийг Өөртэй нь адил болохыг хүссэн учраас Тэрээр төлөвлөгөөг танилцуулсан. Самбарыг гурван хэсэг болгон хувааж, уг хэсгүүд дээр “Өмнөх Амьдрал,” “Мөнх бус амьдрал,” “Үхлийн дараах амьдрал” гэж бич.

Эдгээрийн тухай товч ярилц (Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт [2004], 9–12-ыг үзнэ үү). Хүүхдүүдийг жижиг бүлгүүдэд хуваарилж, бүлэг тус бүрд доорх судруудаас нэг эсвэл түүнээс олон судрыг өг: Эхлэл 1:1; Алма 12:24; Алма 34:32; Алма 40:12; Сургаал ба Гэрээ 76:62; Мосе 4:2; Абрахам 22–23. Бүлэг тус бүрийг авсан судраа уншихад урьж, уг судар нь юуны тухай өгүүлж буйг хүүхдүүдэд хэлээд, судрын эшлэлийг зохих газарт нь самбарт бич.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (зураг зурах): Гурван хэсэг болгон хуваасан хуудас цаасыг хүүхэд бүрд өг. Бурханы төлөвлөгөөний хэсэг бүрийг (өмнөх амьдрал, мөнх бус амьдрал ба үхлийн дараах амьдрал) төлөөлөх ямар нэгэн зүйлийг зурахыг тэднээс хүс. Зурсан зургаа гэртээ хариад гэрийнхэнтэйгээ хуваалцахыг урамшуул. “Би Бурханы төлөвлөгөөг дагана” (ХДН, 164–165) дууллыг хамтдаа дуул.

Хоёрдугаар долоо хоног: Тэнгэрлэг Эцэг хүүхдүүддээ зориулан дэлхийг бүтээхийг Есүс Христэд зарлигласан

Ойлголтыг нь урамшуул (зургуудыг ярилц): Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу бид Түүний оршихуйг орхих хэрэгтэй байсан учраас Тэрээр бидэнд зориулан дэлхийг бүтээлгэхээр Есүс Христыг томилсон гэдгийг тайлбарла.

Бүтээлтийн зарим хэсгүүдийн (нар, сар, ус, ургамал ба амьтад гэх мэтчилэн) зургийг өрөөн дотор тойруулан тавь. Зургийг самбар дээр байрлуулах нэг хүүхдийг сонго. Уг бүтээл нь бидний хувьд яагаад чухал болохыг ярилц. Бүх зургийг самбар дээр байрлуулах хүртэл уг үйл ажиллагааг үргэлжлүүл. Хэн нэгнээр Сургаал ба Гэрээ 59:18–19-ийг уншуулаад, яагаад эдгээр зүйлсийг бүтээснийг сонсохыг хүүхдүүдээс хүс.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (зураг зурах): Хүүхэд бүрд хуудас цаас өгч, дуртай нэг бүтээлээ зурахыг хүс. “Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг” (ХДН, 228–229) дууллыг дуул.



Гуравдугаар долоо хоног: Миний бие махбод Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн

Сургаалыг таньж мэд (*толинд тусгалаа харх*): Хэдэн хүүхдийн өмнө толь барьж, тэднээс харж буй зүйлсээ (нүд, чих, ам гэх мэтчилэн) дүрслэхийг хүс. Тэдний харсан зүйл бол өөрсдийнх нь “дүр төрх” гэдгийг тайлбарла. Хэн нэгнээр Эхлэл 1:27-г уншуулж, бид хэний дүр төрхөөр бүтээгдсэнийг хүүхдүүдээр олж сонго. Бурханд нүд, чих, ам зэрэг эрхтнүүд байдаг учраас бидэнд ч бас эдгээр эрхтнүүд байдаг гэдгийг тайлбарла. (Бурханд ч бас эдгээр эрхтнүүд байдаг гэдгийг тайлбарлахдаа бага насны хүүхдүүдээр гар хөлийг нь хөдөлгүүл эсвэл биеийнх нь өөр өөр хэсэгт хүргүүл.)



Хүүхдүүдийг хичээлд оролцохыг зөвшөөрөх нь суралцах үйл явцад идэвхтэй хамрагдах боломжийг тэдэнд олгодог.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул

(*тоглоом тоглох*): Цаасаар хийсэн шооны тал бүр дээр бие махбодын өөр өөр хэсгүүдийг зур эсвэл нэрийг нь бич. “Их Эзэн Ариун сүм өгсөн” (ХДН, 153) дууллыг дуулах эсвэл хөгжмийг нь сонсох үедээ уг цаасан шоог нэг нэгэндээ дамжуулахыг хүүхдүүдээс хүс. Хөгжмийг гэнэт зогсоож, цаасан шоог барьж буй хүүхдээс шоогоо хаяхыг хүс. “Тэнгэрлэг Эцэг биднийг бие махбоддоо хэрхэн санаа тавиасай хэмээн хүсдэг вэ?” гэж асуу. Цаг байвал энэ мэтээр үргэлжлүүл.



Цаасан шоог олж авах бол энд дар.

Дөрөвдүгээр долоо хоног: Сонгох эрх бол өөрийнхөө төлөө сонгох бэлэг мөн

Сургаалыг таньж мэд (*үзүүлэнт хичээл харх*): Хүүхдүүдийн сонгож болох хэдэн эд зүйлийг авчир. Жишээ нь: Та хоёр өөр төрлийн жимс, үзэг ба харандаа эсвэл хоёр өөр төрлийн гутал авчирч болно. Эдгээр эд зүйлсээс сонгохыг цөөн хэдэн хүүхдээс хүс. Энэхүү сонгох чадварыг “сонгох эрх” гэж нэрлэдэг бөгөөд бид

чөлөөтэй сонгох эрхтэй, гэхдээ хийсэн сонголт бүр маань үр дагавартай гэдгийг тайлбарла.

Ойлголтыг нь урамшуул (*судар унших*): Бид өмнөх амьдралд сүнснүүд байхдаа зөв сонголт хийхэд сонгох эрхээ ашигласан бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар сонгосон гэдгийг хүүхдүүдэд хэл. 2 Нифай 2:27-г уншихыг нэг хүүхдээс хүс. Есүс Христийг дагах эсвэл дагахгүй байхыг сонгосноос ирэх үр дагавруудын тухай уг судар юу хэлж буйг ярилц.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (*дүр бүтээх*): Нэг зарлигийг дагахад сонгох эрхээ ашиглаж болох нөхцөл байдлаар дүр бүтээхийг анги бүрээс хүс. (Жишээ нь: Тэд эцэг эхдээ дуулгавартай байгаагаар эсвэл тоглоомоо найзтайгаа хуваалцаж буйгаар дүр бүтээж болно.) Бусад хүүхдүүдээр хийсэн сонголтынх нь сайн үр нөлөөний тухай яриул.



Бэлтгэл: Хуваалцах цагаа төлөвлөхдөө хамгийн түрүүнд тухайн сарынхаа хичээлүүдийг бүхэлд нь унш. Дараа нь өөрт байгаа цаг болон Хүүхдийн хэсгийн хүүхдүүдийнхээ хэрэгцээнд тохируулан төлөвлөх үйл ажиллагаануудаа тэнцвэржүүл. Жишээ нь: Нэг удаан үргэлжлэх хичээлийн тал хэсгийг нь нэг долоо хоногт үзэж болно, тэгээд дараачийн долоо хоногт үүнийгээ дуусгах эсвэл бататгахад нь хүүхдүүдэд туслах үүднээс богино хэмжээний үйл ажиллагаануудыг давтан хийж болно.

Есүс Христ бол бидний Аврагч

“Эцэг нь Хүүгээ ертөнцийн Аврагч болгон илгээснийг бид үзсэн бөгөөд гэрчилж байна” (1 Иохан 4:14).

Дуу: “Би гайхширна”
(Сүмийн дуулал, 193)

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Би Есүс Христийн тухай гэрчлэлээ өсгөж чадна

Сургаалыг таньж мэд (түүх сонсох): Дараах түүхийг ярь: “Ерөнхийлөгч Жэймс Э.Фауст хүүхэд байхдаа нэгэн удаа хар дарж зүүдлээд уйлан сэржээ. Эмээ нь түүнийг тэвэрч, тайвшруулаад Есүс Христ тэднийг харж хандаж байгаа учраас тэд аюулгүй байгаа гэдгийг хэлэв. Тэгээд тэрээр Есүс биднийг харж хамгаалдаг гэдэгт огтхон ч эргэлзэлгүйгээр ор руугаа явжээ.” Уг туршлага нь Есүс Христийн тухай гэрчлэлтэй болоход нь Ерөнхийлөгч Фаустад тусалсан гэдгийг хүүхдүүдэд хэл (“A Growing Testimony” *Ensign*, 2000 оны 11-р сар, 53-ыг үзнэ үү).

Ойлголтыг нь урамшуул (тоглоом тоглох): Хэн нэгэнд гэрчлэлтэй болоход нь тусалж чадах эсвэл тусалж чадахгүй зүйлсийг дүрсэлсэн үгсийг бичсэн 10 ширхэг цаасан туузыг бэлтгэ (цаасан туузны загварыг sharingtime.lds.org-оос үзэх боломжтой). Арван хэсэг болгон зангидсан урт олс эсвэл уяаг шалан дээр тавь. Нэг хүүхдийг “Би Есүс Христийн тухай” гэсэн тэмдгийг барин, олсны үзүүрийн хэсэгт зогсохыг хүс. Өөр нэг хүүхдийг “Гэрчлэлээ өсгөж чадна” гэсэн тэмдгийг барин, олсны нөгөө үзүүрт зогсохыг хүс. Нэг хүүхдээр нэг цаасан тууз сонгуулж, чангаар уншуул. Хэрэв гэрчлэлтэй болоход маань бидэнд тусалж чадах зүйлийг дүрсэлсэн байвал тухайн хүүхдийг “Гэрчлэлээ өсгөж чадна” гэсэн тэмдэг рүү нэг зангилаагаар урагш алхуул. Харин гэрчлэлтэй болоход маань тусалж чадахгүй зүйл байвал уг хүүхдийг зогссон байранд нь үлдээ. Уг хүүхдийг олсны нөгөө үзүүрт хүрэх хүртэл үүнийг давтан хий. Хүн бүрээр “Би Есүс Христийн тухай гэрчлэлээ өсгөж чадна” гэж хэлүүл. Бид амьдралынхаа турш Есүс Христийг дагахаа үргэлжлүүлж, зөв сонголтууд хийснээр бидний гэрчлэл илүү хүчирхэг болон өсдөг бөгөөд хэзээ ч өсөхөө больдоггүй гэдгийг тайлбарла.



Туузан дээр бичсэн үгс рүү энд дарж орно уу




гэрчлэлээ өсгөж чадна

Хоёрдугаар долоо хоног: Би Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан наманчилж мөн нүглүүдээсээ өршөөгдөж чадна

Сургаалыг таньж мэд (зургуудыг ярилцах): Гетсеманийн цэцэрлэг дэх Аврагчийн зургийг үзүүлж, Цагаатгалыг товчхон дурд (Лук 22:39–44-ийг үзнэ үү). Сургаал ба Гэрээ 19:16-г уншихыг нэг хүүхдээс хүс, тэгээд хүүхдүүдийг Цагаатгалаас ирдэг адислалуудад баяр хөөртэй байхын тулд бид юу хийх ёстой талаар олж сонсохыг хүс.

Ойлголтыг нь урамшуул (судрын түүх сонсох): Бага Алмагийн түүхийг ярьж өгөөд, үүнтэй зэрэгцэн өөртэйгөө хамт үйл хөдлөлөөр үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Дараах жишээг хар: “Бага Алма буруу сонголтууд хийж байв (царайгаа ширүүн төрхтэй болгоно). Тэр найзуудтайгаа Сүмийг устгахыг оролдож байв. Нэгэн өдөр тэнгэр элч тэднийг зогсоохоор ирэв. Алма ихэд айжээ (айсан дүр үзүүлнэ). Тэр маш их



Жүжигчилсэн тоглолт хийх нь бүх хүүхдүүдийг оролцуулах боломжийг олгодог.

айсан учраас үхсэн мэт газарт унав (үхсэн юм шиг унана). Тэрээр нүглүүдийнхээ төлөө харамсаж, гурав хоногийн турш хөдөлж чадсангүй (хөдөлгөөнгүй хэвтэнэ). Эцэст нь тэр нүглүүдийнх нь төлөө Есүс Христ бүгдийг төлж, цагаатгасныг санажээ. Есүсийн хийсэн зүйлийн тухай бодохдоо тэрээр агуу баяр баяслыг мэдрэв (баярлан үсэрнэ). Алма наманчилж, Есүс

Христийн тухай хүмүүст заадаг агуу бошиглогч болжээ” (Алма 36-г үзнэ үү).

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул

(**ярилцах**): Доор дурдсан наманчлалын зарчмуудыг товч ярилц: (1) буруу зүйл хийснээ ухаар, (2) хийсэн нүглийнхээ төлөө гэмш, (3) Тэнгэрлэг Эцэгт буруугаа хүлээ, (4) алдаагаа зас, тэгээд (5) дахин бүү хий.

Гуравдугаар долоо хоног: Есүс Христ амилсан, тиймээс би ч бас амилах болно

Сургаалыг таньж мэд (дуу дуулах): “Есүс үнэхээр амилсан уу?” дууг хамтдаа дуул. (ХДН, 64) эсвэл “Тэр амилсан” (ХДН, 70) дууллыг хамтдаа дуул. Уг дууны юу зааж буйг тайлбарлахыг нэг хүүхдээс хүс. Есүс Христ амилсан, тиймээс бид ч бас амилах болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Судруудыг гартаа бариад, судруудаас энэ тухай уншдаг болохоор Есүс Христ амилсныг бид мэднэ гэдгийг тайлбарла. Хэдийгээр бид амилсан Христийг хараагүй ч, бусад хүмүүс харсан бөгөөд тэд мэддэг зүйлсээ бидэнд хэлсэн юм.

Ойлголтыг нь урамшуул (үг хэлэхээр ирсэн зочдыг сонсох): Тойргийнхоо насанд хүрсэн хэдэн гишүүнийг хуваалцах цагийн үеэр ирж, амилсан Христийг харсан доорх гэрчүүдийн нэгийг нь дүрслэхийг хүс: Магдалын Мариа (Иохан 20:1–18-ыг үз), Томас (Иохан 20:19–29-ийг үзнэ үү), Нифай үндэстний эрэгтэй, эмэгтэй хүн (3 Нифай 11:1–17; 17-г үзнэ үү) ба Иосеф Смит (Иосеф Смит—Түүх 1:11, 14–17; С ба Г 76:22–24-ийг үзнэ үү). Тойргийн гишүүдийг Христийн Амилалтын тухай судрын бичээс болон хувийн гэрчлэлээ хуваалцахыг хүс.

Дөрөвдүгээр долоо хоног: Би бишрэлтэй байснаар Аврагчид хүндэтгэл үзүүлж чадна

Ойлголтыг нь урамшуул (зургуудыг үзэх): Гетсеманийн цэцэрлэг, Есүсийн булш, Ариун ойн цоорхой, ариун сүм болон цуглааны байр зэрэг ариун нандин газруудын зургуудыг үзүүл. Зураг бүрийг үзүүлэхдээ, “Яагаад энэ газар ариун эсвэл онцгой вэ? Хэрэв чи тэнд байсан бол хэрхэн биеэ авч явах байсан бэ?” гэж асуу. Хүндэтгэл бишрэл гэж юу болох, хүндэтгэлтэй үйлдлүүд нь Аврагчийн төлөөх бидний хайр, хүндлэлийг хэрхэн харуулдгийг ярилц. Бид хүндэтгэл бишрэлтэй байхдаа Түүнд ойр байдгийг мэдэрдэг гэдгийг тайлбарла.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (жишээнүүдийг бодох): Самбар дээр “Хүндэтгэл бишрэлтэй” ба “Хүндэтгэл бишрэлгүй” гэж бич. Хүүхдүүдийг хэдэн бүлэг болгон хуваарил. Бүлэг бүрд жижиг хуудас цааснуудыг өгч, сүм дээрх бишрэл хүндэтгэлийг харуулдаг эсвэл харуулдаггүй ямар нэгэн юмыг цаас болгон дээр бичихийг хүс. Бүлэг бүрээр цааснуудыг нь ээлжээр уншуул. Хүүхдүүдээс хэрэв энэ нь хүндэтгэл бишрэлтэй жишээ бол гараа элгэндээ гэвэрч, харин хүндэтгэл бишрэлгүй бол гарынхаа хуруунуудыг хөдөлгөхийг хүс. Тэгээд цаасыг самбар дээр зөв гарчгийн дор байрлуулахыг бүлгийн нэг гишүүнээс хүс.

Зөвлөгөө: Хуваалцах цагийн хичээлээ төлөвлөх үедээ цагаа сайтар бодолцоорой. Жишээ нь: Гуравдугаар долоо хоногийн үйл ажиллагаанд үг хэлэхээр ирсэн зочин тус бүрээс хоёр минут ярихыг хүс. Та хүн бүрд илүү хугацаа олгох үүднээс арай цөөн үг хэлэгчийг урьж болно.



Тоглоомууд: Хүүхдийн хэсэгт тохирсон тоглоомууд нь хүндэтгэл бишрэлтэй уур амьсгалыг хадгалахад тусалдаг. Тоглоомууд нь хичээлд олон зүйлийг нэмж, хүүхдүүдийг нэг нэгэндээ харилцан нөлөөлөх боломжийг олгодог. Тэд хөгжилтэй арга замаар заалгаснаар сайн мэдээний зарчмуудыг бататгадаг.

Гэр бүл бол Бурханы төлөвлөгөөний ТӨВ ХЭСЭГ

Дуу: “Бурханы гэр бүл”

(уг тоймын 28–29 дүгээр хуудас)

Зөвлөгөө: Та гэр бүлүүдийн тухай заахдаа Хүүхдийн хэсэг дэх хүүхдүүдийнхээ гэр бүлийн нөхцөл байдал мэдрэмжтэй ханд. Хэзээ нэгэн өдөр өөрсдийн мөнхийн гэр бүлүүдтэй болохын тулд одооноос зөв зохистой амьдарч, бэлтгэхэд нь бүх хүүхдийг урамшуул.



“Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Гэр бүл бол Бурханы төлөвлөгөөний төв хэсэг

Сургаалыг таньж мэд (орхигдсон үгсийг олох):

Хүүхдийн хэсэг эхлэхээс өмнө хоёр сандлын доод талд “Гэр бүл” болон “Төв хэсэг” гэсэн үгсийг нааж тогтоо. Самбар дээр “_____ бол Бурханы төлөвлөгөөний _____” гэж бич. Хүүхдүүдийг сандлынхаа доод талаас орхигдсон үгсийг олоход урь. Олсон хүүхдүүдийг үгсээ самбар дээр зохих хоосон зайнд нь тогтоохыг хүс. Уг өгүүлбэрийг хамтдаа хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг нь урамшуул (гэр бүлүүдийн тухай ярилцах ба дуу дуулах):Төв хэсэг гэдэг нь “чухал шаардлагатай хэсэг” гэсэн үг болохыг тайлбарла. Хүүхдүүдийг гэр бүлийнхээ гишүүдийн тоогоор гарынхаа хурууг гаргахыг хүсээд, хэрхэн хүн нэг бүр нь гэр бүлийн нэг хэсэг болдгийг ярилц. “Гэр бүл үүрд хамт байх болно” (ХДН, 188) дууллыг дуул.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (зураг зурах): Хүүхдүүдээс том тойрог зурж, тойргийн голд гэр бүлээ зурахыг хүс. Зургуудыг гэртээ авч очин гэр бүл бол Бурханы төлөвлөгөөний төв хэсэг гэдгийг гэрийнхэндээ заахад нь хүүхдүүдийг урамшуул.



Хоёрдугаар долоо хоног: Эцэг эхчүүд гэр бүлдээ чухал үүрэг хариуцлагатай

Сургаалыг таньж мэд (дуулах): Хүүхдүүдээс Хүүхдийн хэсгийн дуртай дуулаа бодохыг хүс. Таныг гурав хүртэл тоолоход хүүхдүүд босоод дуунуудаа зэрэг дуулах ёстой гэдгийг тэдэнд хэл. Гурав хүртэл тоолоод тэднийг дуулуул. Дуулахыг нь зогсоогоод, нэг ижил дуу дуулахад нь хөгжмийн удирдагчаар удирдуул. Тэднийг удирдах хөгжмийн удирдагчгүйгээр будлиан үүссэн гэдгийг онцол. Хэрэв Тэнгэрлэг Эцэг гэр бүлийг удирдах чухал үүрэг хариуцлагыг эцэг эхчүүдэд өгөөгүй бол бидний гэр оронд ч бас будлиан үүсэх байсныг тайлбарла.

Ойлголтыг нь урамшуул (эцэг эхийн үүргийг хэлэлцэх): Хоёр хөвгүүн мөн хоёр охиныг урагш гарч ирэхэд урь. Хүүхэд бүрээр гэр бүлийн гишүүдийг (аав, ээж, хүү, охин) төлөөлүүл. “Аав”-ын дэргэд зогсоод, гэр бүлийнхээ патриарх нь байж гэр бүлээ тэргүүлэх, хэрэгцээтэй зүйлсээр хангах, тэднийг хамгаалах нь эцгийн үүрэг хариуцлага гэдгийг тайлбарла. Эдгээр үүргүүдээ гүйцэтгэхийн тулд аавуудын хийдэг зүйлсээс жишээ хэлэхийг хүүхдүүдээс хүс мөн тэдний юу дүрсэлснийг үйлдлээр үзүүлэхийг



Хүүхдүүдэд заахдаа үзүүлэн таниулах материалуудыг хэрэглэх нь тэдний анхаарлыг татаж, тэднийг суралцахад бэлтгэдэг.

“аав”-аас хүс. “Ээж” -ийн дэргэд зогсоод, гэр бүлээ асран хамгаалж, хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх нь эхийн үүрэг хариуцлага гэдгийг тайлбарла. Эдгээр үүргүүдээ гүйцэтгэхийн тулд ээжүүдийн хийдэг зүйлсээс жишээ хэлэхийг хүүхдүүдээс хүс мөн тэдний юу дүрсэлснийг үйлдлээр үзүүлэхийг “ээж”-ээс хүс. Эцэг эхчүүдийн аль аль нь сайн үлгэр жишээ байж, сайн мэдээг заах үүрэг хариуцлагатай гэдгийг

Гуравдугаар долоо хоног: Хүүхдүүд эцэг эхээ дуулгавартай дагах үүрэг хариуцлагатай

Сургаалыг таньж мэд (судар унших): Хүүхдийн хэсэг эхлэхээс өмнө Ефес 6:1-ийг бичсэн цаасыг нуу. Нэг хүүхдийг босгон, нуусан цаасыг олоход нь чиглүүл. Жишээ нь: Та түүнд “Урагшаа гурав том алхам алх. Зүүн гар тал руугаа зургаа алхам алх” гэж хэлж болно. Уг хүүхэд цаасыг олсон үед бусад хүүхдээр судрын эшлэлийг судар дээр нь олуулж, нэг хүүхдээс үүнийг чангаар уншихыг хүс. “Эзэн дотор” гэдэг нь “зөвийг хийхэд” гэсэн үг болохыг тайлбарла.

Дөрөвдүгээр долоо хоног: Би гэр бүлийнхээ гишүүн бүрд хайраа харуулж чадна

Ойлголтыг нь урамшуул (таах тоглоом тоглох ба дуу дуулах): Дараах гэр бүлийн гишүүдийн түлхүүр үгсийг хүүхдүүдэд өгөөд таныг аав, ээж, ах, эгч, эмээ, өвөө, авга болон нагац эгч, авга болон нагац ах, үеэлийн хэнийг нь дүрсэлж буйг тэд мэдэх үедээ хамартаа хүрэхийг хүүхдүүдээс хүс. Жишээ нь: Авга эгчийн тухай түлхүүр үгс нь: “Би бол эмэгтэй. Би чиний аавтай хамт өссөн. Би чиний үеэлийн ээж” байж болно. Хүүхдүүд гэр бүлийн гишүүнийг зөв таах үед нэг хүүхдэд уг гишүүнийг төлөөлөх даалгавар өгөөд, ангийн урд гарч зогсоход урь. Зарим гэр бүлүүдэд гэр бүлийн эдгээр бүх гишүүд байж болно эсвэл байхгүй ч байж болно. Бүх гэр бүлүүд ялгаатай хэдий ч, тэдэнд бүгдэд нь нэг нийтлэг зүйл—хайр байдаг гэдгийг тайлбарла. “Аз жаргалтай гэр бүл” (ХДН, 198) дууллыг хамтдаа дуул.


Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (гэр бүлүүдийн тухай ярилцах): Нэг хүүхдэд байшингийн зураг бариул. Хэдэн хүүхдийг урьж, байшиндаа хамт амьдардаг гэр бүлийн гишүүд болон тэдэнд хайраа харуулдаг арга замуудыг нь нэрлүүл. Хоёр дахь хүүхдийг эхний хүүхдийн хажууд зогсоон, өөр нэг байшингийн зураг бариул. “Хэн чинь ойр амьдардаг гэр бүлийнхэнтэй вэ? “Чи тэдэнд хайртайгаа хэрхэн харуулдаг вэ? гэж асуу. Эцэст нь гурав дахь хүүхдийг гаргаж, өөр нэг байшингийн зураг бариулаад нөгөө

хүүхдүүдэд хэл. Эцэг эхчүүд гэр бүлдээ хэрхэн зааж чадахыг төлөөлсөн ямар нэгэн зүйлийг анги бүрд өг (Жишээ нь: судрууд, гэр бүлийн үдшийн гарын авлага эсвэл гэр бүл хамтдаа хоол идэж, залбирч, ажиллаж байгааг дүрсэлсэн зургууд). Анги бүрээс нэг хүүхдийг урьж, тэдний эцэг эх нь гэр бүлдээ туслахын тулд эдгээрийг хэрхэн ашиглаж болохыг хэлэхийг хүс.

Ойлголтыг нь урамшуул (судрын түүхийг ярилцах): Лихай гуулин ялтсуудыг авахаар хөвгүүдээ илгээж буй түүхийг ярь (1 Нифай 3–4-ийг үз). “Хүүхдүүд нь хэн байсан бэ? Эцэг нь хэн байсан бэ? Эцгийн хүссэн зүйл юу вэ? Дуулгавартай дагахад хялбар байсан уу? Хүүхдүүд эцгийгээ дуулгавартай дагах үед юу тохиолдсон бэ?” зэрэг асуултуудыг асууж түүхийг дахин бататга.

хоёр хүүхдээс хол газар зогсоо. “Та нарын хэн нэгэнд чинь хол амьдардаг гэр бүлийн гишүүд бий юу?” гэж асуу. Хүүхдүүд тэдгээр гэр бүлийн гишүүдэд хайраа үзүүлж чадах арга замуудыг ярилц. Ирэх долоо хоногийн турш гэр бүлийнхээ гишүүдэд хайраа үзүүлэх нэг арга замыг сонгоход нь хүүхдүүдийг урамшуул.

Хайраа харуул: Зааж байгаа хүүхдүүдээ хайрлаж буйгаа харуулахын тулд тэдний хийсэн зүйлсэд чин сэтгэлийн магтаал хэл. Жишээлбэл: Та зүгээр л “маш сайн” эсвэл “баярлалаа” гэж хэлэхийн оронд “Гэр бүлийнхээ тухай түүхийг хуваалцсанд баярлалаа” гэх мэт тодорхой магтаал хэлж байгаарай.



Гэр бүлүүд бошиглогчийг дагаснаар адислагддаг

“Ариун эш үзүүлэгчдээр урьдаас хэлүүлсэн үгсийг санагтун” (2 Петр 3:2).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнснийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Дуу: Хүүхдийн дууны ном, Дууллууд, эсвэл Сүмийн сэтгүүлүүдээс таны сонгох дуу

Нэгдүгээр долоо хоног: Бурхан бошиглогчдоор дамжуулан бидэнтэй ярьдаг

Сургаалыг таньж мэд: (үг дамжуулах): Нэг хүүхдийн чихэнд “Бурхан бошиглогчдоор дамжуулан бидэнтэй ярьдаг” гэж шивнэ. Тэгээд түүнээс үүнийг өөр хүүхдэд шивнэн хэлэхийг хүс, тэгээд хүүхэд бүр уг захиасыг хүлээн авах хүртэл бүх хүүхдэд дамжуул. (Олон хүүхэдтэй Хүүхдийн хэсэгт энэ үйл ажиллагааг хийхдээ жижиг бүлгүүд болгон хуваа.) Хамгийн сүүлчийн хүүхдийг босож зогсоод сонссон захиасаа чангаар хэлэхийг хүс. Хүүхдүүд захиасыг нэг нэгэндээ дамжуулсан шиг Бурхан Өөрийнх нь өмнөөс ярихыг (эсвэл захиасуудыг дамжуулахыг) бошиглогчдоос хүсдэг гэдгийг онцол.

Ойлголтыг нь урамшуул (судруудыг унших ба бусдад заах): Хүүхдүүдэд Ноагийн зургийг харуул. Хүүхдүүдийг дөрвөн бүлэгт хуваарил. Бүлэг бүрд доорх судрын эшлэлүүдийг

өг: Моисе 8:20–26; Эхлэл 6:13–17; Эхлэл 6:18–22; Эхлэл 7:7–12.

Бүлэг бүрийг хуваарилж авсан судруудаа уншиж, сурсан зүйлээ бусад хүүхдүүддээ ээлжлэн ярьж өгөхийг хүс. Ноагийн захиасыг дагасан эсвэл дагаагүй хүмүүст юу тохиолдсон гэж бодож байгааг нь хүүхдүүдээс асуу (Эхлэл 7:23-ыг үзнэ үү). Бурхан бошиглогчдоороо дамжуулан бидэнтэй ярьдаг бөгөөд хэрэв бид тэднийг дагавал аюулгүй байх болно гэдгийг гэрчил.



Хүүхдүүдийг хичээлд оролцохыг зөвшөөрөх нь суралцах үйл явцад идэвхтэй хамрагдах боломжийг тэдэнд олгодог.

Хоёрдугаар долоо хоног: Судрууд дахь бошиглогчид нь манай гэр бүлийн үлгэр жишээ мөн

Сургаалыг таньж мэд (үлгэр жишээг дагах): Энгийн хэмнэлтэйгээр алгаа ташиж, өөрийн чинь жишээг даган давтаж хийхийг хүүхдүүдээс хүс. Үлгэр жишээ гэж юу болох тухай ярилц. Бидний хувьд судрууд дахь бошиглогчид нь дагах ёстой үлгэр жишээнүүд мөн гэдгийг тайлбарла.

Ойлголтыг нь болон сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (судруудаас унших): Хүүхдүүдийг бүлгүүдэд хуваа. Бүлэг бүр дэх нэг насанд хүрэгчид доорх үг бичсэн цаасан туузнуудаас нэгийг өгч, цаасан туузан дээр жагсаасан судруудыг бүлгийнхээ хүүхдүүдэд уншиж өгөхийг хүс.

Баптисм хүртээгч Иохан: С ба Г 84:27–28 (баптисм хүртсэн)

Бага Алма: Мозая 27:23–24 (наманчилсан)

Иошуа: Иошуа 24:15 (Их Эзэнд үйлчилсэн)

Хаан Бенжамин: Мозая 2:17–18 (бусдад үйлчилсэн)

Лихай: 1 Нифай 1:5 (залбирсан)

Нифай: 1 Нифай 3:7 (зарлигуудыг сахисан)

Жаредын ах: Ифер 3:9 (итгэлтэй байсан)

Үлгэр жишээ болох ямар зүйлийг тухайн бошиглогч хийснийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Бүлэг бүрийг өөрсдийн бошиглогчийн тухай шүлэг зохиож, үүнийгээ “Бошиглогчийн дага” (ХДН, 110–111) дууллын аянд оруулж дуулахыг хүс. Тэднийг зохиосон шүлгээ бусад хүүхдүүдтэй хуваалцахад урь.

Сургаалыг давтах:

Энэ сард хүүхдүүд гэр бүлүүд бошиглогчийг дагахдаа адислагддаг гэсэн сургаалын өөр өөр судрын зурагт тайлбарыг сурах болно. Долоо хоног бүр сургаалыг ярихад нь хүүхдүүдийг урихад анхаар.

Гуравдугаар долоо хоног: Бид бошиглогчийг дагаснаар гэр бүл маань адислагдана

Сургаалыг таньж мэд (зааврыг дагах): “Бид бошиглогчийг дагаснаар гэр бүл маань адислагдана” гэж бичсэн цаасан тууз бэлдээд, Хүүхдийн хэсэг эхлэхээс өмнө ангид нуу. Таны зааврыг дагаж, цаасан туузыг олох нэг хүүхдийг

урь. Уг хүүхэд өөрийн чинь зааврыг дагаж байгаа шиг бидний гэр бүлүүд бошиглогчийн заавруудыг дагаж чадна гэдгийг тайлбарла. Цаасан туузнуудыг хамтдаа уншихыг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг нь урамшуул (*үг хэлэгчдийг сонсох*): Хэдэн гэр бүлтэй урьдчилан холбоо бариад, бошиглогчийг дуулгавартай дагах нь тэдний гэр бүлүүдийг хэрхэн адисалсан тухай Хүүхдийн хэсэгт ирж хуваалцахыг хүс.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (*дуулах ба ярилцах*): Одоогийн бошиглогчийн зургийг харуулаад, бид өнөөдөр бошиглогчоор

удирдуулдаг бөгөөд түүний үгийг сонсож, дагаснаараа адислагдах болно гэдгийг тайлбарла. “Би дуулгавартай байна” (*ХДН, 197*) дууллын эхний мөрийг нь “Бошиглогчид надад хэлэх үед” болгон өөрчилж дуул. Саяхны ерөнхий чуулган дээр бошиглогчийн өгсөн удирдамж болон зөвлөмжийг олж танилцуул. Хүүхдүүдийн заримаас нь уг зөвлөмжийг дагаснаар тэдний гэр бүлүүд хэрхэн адислагдах тухай хуваалцахыг хүс.

Дөрөвдүгээр долоо хоног: Ерөнхий чуулган дээр бошиглогч бидэнд хандан ярьдаг

Сургаалыг таньж мэд (*сургууд руу харах*): Хүүхдүүдийг хэрэв тэд сүмийг хэн удирддагийг мэддэг бол босож зогсохыг хүс. Бошиглогчийн зургийг үзүүлж, түүний нэрийг хэн болохыг хүүхдүүдээс асуу. Түүгээр дамжуулан Бурхан бидэнтэй ярьдаг гэдгийг тайлбарла. Чуулганы Төвийн зургийг үзүүл. Ерөнхий чуулганы үеэр бошиглогч бидэнд хандан энэ барилгаас ярьдаг болохыг хүүхдүүдэд хэл.

Ойлголтыг нь урамшуул (*судрын түүхийг ярилцах*): Бурхан бошиглогчдоор дамжуулан хүүхдүүдтэйгээ үргэлж ярьдаг байсныг хүүхдүүдэд хэл. Хаан Бенжамин зургийг үзүүлээд, Мозая 2:1–8 дахь түүхийг ярьж өг. Уг түүхийг биетээр үзүүлэхэд хүүхдүүдийг урь. Хаан



Бенжамин цамхаас хандан ярьсан бөгөөд хүн бүхэн уншиж болохын тулд түүний хэлсэн үгийг бичиж авч байсныг хүүхдүүдэд сануул. Хаан Бенжамин энэхүү түүхийг өнөө үед ерөнхий чуулганы үеэр болдог зүйлтэй харьцуулахыг хүүхдүүдээс хүс.



Энгийн хувцас хэрэглэлүүдийг ашиглах нь Хүүхдийн хэсгийн хичээлүүдийг сайжруулж, хүүхдүүдийн анхаарлыг татаж чадна.



Хайраа үзүүл: “Зааж буй тэдэндээ хайраа үзүүлэх нь тэднийг Сүнсэнд илүү дуулгавартай болгодог” (*TNGC, 31*). Хүүхдүүдийн төлөө нэг бүрчлэн залбирснаар, тэдний хүсэл сонирхол, асуудлуудыг мэдсэнээр, тэднийг нэрээр нь дуудаж, анхааралтай сонссоноор таны хүүхдүүдийг хайрлах хайр өсөх болно.

Санваарын ёслолууд ба Ариун сүмийн ажил гэр бүлийг адисалдаг

Дуу: Хүүхдийн дууны ном, Дууллууд, эсвэл Сүмийн сэтгүүлүүдээс таны сонгох дуу


“Та нар газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно” (Матай 18:18).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүмийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Санваарын ёслолууд гэр бүлийг адисалж мөн бэхжүүлдэг

Сургаалыг таньж мэд (дуу дуулах): “Хайр энд байна” (ХДН, 190–191) дууллын хоёрдугаар бадгийг хамтдаа дуулахдаа гэр бүлүүдийг нь адисалдаг ямар нэгэн зүйлийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Санваарын ёслолууд нь бүх гэр бүлүүдийг адисалж мөн бэхжүүлж чадна гэдгийг тайлбарла.

Ойлголтыг нь урамшуул (зургуудыг ярилцах): Хүүхдүүдийг бүлгүүдэд хуваарилж, бүлэг тус бүрд нэг санваарын ёслолын зургийг өг. Бүлэг бүрээс зураг дээр харуулсан санваарын ёслолыг бусад хүүхдүүд таахад туслах зарим дөхүүлэх санаануудыг бодож олохыг хүс (Жишээ нь: “Энэ ёслол нь ням гараг бүр сүм дээр болдог”). Бүлэг бүрийг дөхүүлэх санаануудаа хуваалцаж, хүүхдүүдийн дүрсэлж буй санваарын ёслол юу болохыг нь бусдаар таалга. Тэднийг зөв таасны дараа уг ёслол биднийг хэрхэн адисалдгийг ярилцаад, зургийг самбар дээр байрлуул.



Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (туршлагауудаа хуваалцах): Гэртээ очоод санваарын ёслолууд тэдний амьдралыг адисалж мөн бэхжүүлсэн тухай гэр бүлийнхэнтэйгээ ярилцахад нь хүүхдүүдийг урь.



Бусдад заах: Хүүхдүүд Хүүхдийн хэсэгт сурсан зүйлсээ бусадтай хуваалцах нь тэдний сургаалын талаарх ойлголт болон гэрчлэлийг бэхжүүлдэг. Энэ сард тэднийг сурсан зүйлээ гэртээ хуваалцахыг урамшуулан дэмжиж байна. Энэ нь тэднийг сайн мэдээний тухай гэртээ ярилцах боломжоор хангаж мөн гэр бүлийг бэхжүүлдэг.

Хоёрдугаар долоо хоног: Ариун сүмүүд гэр бүлүүдийг үүрд хамт байхыг боломжтой болгодог

Сургаалыг таньж мэд (дуу дуулах): Амьдардаг газарт чинь хамгийн ойр орших ариун сүмийн зургийг хүүхдүүдэд үзүүл. “Би Ариун Сүм харах дуртай” (ХДН, 95) дууллын эхний бадгийг дуулахыг хүүхдүүдээс хүс. “Би нэгэн цагт тэнд очно” гэсэн мөрийг онцлоод, уг дууны хоёрдугаар бадгийг хамт дуулах үедээ яагаад Сүмийн гишүүд ариун сүм рүү явдаг болохыг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Тэдний хариултуудыг ярилцаад, ариун сүмийн ёслолууд нь гэр бүлүүд үүрд хамт байхыг боломжтой болгодог гэдгийг цохон тэмдэглэ.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (зураг зурах): Дээр нь ариун сүмийг энгийнээр дүрсэлсэн хуудас цаасыг хүүхэд бүрд өг (sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно). Гэр

бүлийн гишүүдээ ариун сүмийн дэргэд гар гараас нь хөтлөлдүүлэн зурахыг хүүхдүүдээс хүс. Зурсан зургаа гэртээ очоод гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг урамшуул.



Хүүхдүүдээр зураг зуруулах нь сургаалын тухай ойлголтоо бататгах боломжийг тэдэнд олгодог.

Энд дарж Ариун сүмийн зураг руу орно уу

Гуравдугаар долоо хоног: Би Ариун сүмд орохоор зохистой байхын тулд одооноос бэлтгэж чадна


Сургаалыг таньж мэд (дуу дуулах): “Би Ариун сүм харах дуртай” (ХДН, 95) дууллын эхний бадгийг дуулах үедээ тэдний нандин үүрэг нь юу болохыг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүд том болоод ариун сүмд орохын тулд одооноос бэлтгэж чадна гэдгийг тэдэнд хэл.

Ойлголтыг нь урамшуул (зохистой байдлын тухай ярилцах): Ариун сүмийн зургийг үзүүл. Ариун сүм нь ариун газар учраас зөвхөн зөв зохистой хүмүүс л орж чадна гэдгийг тайлбарла. Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь жишгүүдийн дагуу амьдрах нь биднийг зөв зохистой байхад бэлтгэх болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Жишгүүдээс заримыг нь салангид цаасан туузнууд дээр бич. Хүүхдүүдийг бүлгүүдэд хуваарилж, бүлэг тус бүрд нэг цаасан тууз өг. Бүлэг бүрийг босгоод уг жишгийн дагуу амьдрах нь ариун сүмд ороход зохистой байхад нь тэднийг хэрхэн бэлтгэх тухай тайлбарлахыг хүс.



Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул

(тоглоом тоглох): Хуудас цааснууд дээр нүд, ам, чих, гар, хөлийг тус тусад нь зур (загвар зургуудыг sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно). Төгөлдөр хуурчийг “Би Ариун Сүм



Энд дарж загвар зургууд руу орно уу

харах дуртай” дууллыг тоглох үеэр зурсан зургийг нэг нэгэндээ дамжуулахыг хүүхдүүдээс хүс. Хөгжим зогсоход зургийг барьж буй хүүхдээс ариун сүмд ороход бэлтгэхийн тулд тэд бие махбодын энэ хэсгээр юу хийж болохыг хэлэхийг хүс (Жишээ нь: Тэд амаараа залбирч, найрсаар ярьж мөн үнэнийг хэлж болно). Цаг байвал үргэлжлүүлэн хий.

Дөрөвдүгээр долоо хоног: Гэр бүлийн түүхийн ажил намайг өвөг дээдэстэй минь холбодог

Ойлголтыг нь урамшуул (дуу дуулах ба түүх сонсох): Дараах түүхийг ярь. Өөрийг чинь “дуул” гэж хэлэх үед бүх хүүхдүүдийг “Би гэр бүлийнхээ түүхийг хөтөлдөг” (ХДН, 94) дууллыг дуулахыг хүс. Зөвхөн эхний өгүүлбэрийг дуулснаар эхэлж, дуулах бүрдээ өөр өгүүлбэрүүдийг нэм. “Нэгэн гэр бүл дуу хөгжимд дуртай. Тэдний өвөг дээдэс Мэри Жонс болон түүний эцэг эх мөн дуу хөгжимд дуртай байсныг тэд гэр бүлийн түүхээсээ суралцжээ. Жонсийн гэр бүл мөн сүмд хайртай байв. Тэд Уэйлсийн нутагт баптисм хүртэцгээж, тэгээд Юта руу нүүхээр шийджээ. Мэригийн эцэг эх хоёр аяны үеэр нас барахад тэр хэдийгээр бяцхан охин байсан боловч, Мэри тэгш талыг гатлахаа үргэлжлүүлж,



ингэхдээ аавынхаа бичсэн сүмийн дууллуудыг хийсэн модон хайрцгийг авч явжээ. Мэри хожим хүүхдүүдээ дуулах дуртай болгон сургажээ. Өнөөдөр түүний жич хүүхдүүд нь мөн дуулах дуртай. Эдгээр хүүхдүүд Мэритэй холбогдсон бөгөөд тэрээр сүм болон дуулахад зориулсан хайраа үе удамдаа доош дамжуулсныг мэднэ.”

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул

(будгах): “Би,” “Миний өвөг дээдэс” гэж бичсэн хоёр хуудас цаасыг хүүхэд бүрд өг. “Би” гэж бичсэн цаасан дээр өөрсдийгөө зурахыг тэднээс хүс. Тэгээд гэртээ очоод нэг өвөг дээдсийнхээ тухай эцэг эхээрээ яриулаад, уг өвөг дээдсээ нөгөө цаасан дээрээ зурахыг тэднээс хүс.

Дуунууд: Шинэ дууг хүүхдүүдтэй дуулахдаа нэг мөрийг хүүхдүүдэд дуулж өгөөд, тэднээс дагаж дуулахыг хүс. Мөр болгоныг нь давт.

Бид баптисм ба баталгаагаар дамжуулан сүмийн гишүүд болдог

Дуу: “Баптисм”
(ХДН, 100–101)

“Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” (Иохан 3:5).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Есүс Христийн Сүм сэргээгдсэн

Сургаалыг таньж мэд (зураг харах): Бошиглогч Иосеф Смитийн зургийг харуулаад, түүний тухай мэддэг зүйлсээ хуваалцахыг хүүхдүүдээс хүс. Есүс Христийн Сүм Иосеф Смитээр дамжин сэргээгдсэнийг тайлбарла.

Ойлголтыг нь урамшуул (үзүүлэнт хичээл харах): Есүс Христ дэлхий дээр байхдаа санваарын удирдлага болон үнэн сургаалтай Сүмээ зохион байгуулсан гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс сүм дэх зарим сургаалууд болон удирдах байр суурийг нэрлэхийг хүс, тэгээд хариулт хэлэх болгонд нь тэднээр ширээн дээр байгууламж бариулахын тулд хавтан өрүүл. Уг байгууламжийг барьж дуусаад энэ нь Есүс Христийн Сүмийг төлөөлж байгааг тайлбарла. Христийн цовдлуулалт болон амилалтын зургийг үзүүлээд, эдгээр үйл явдлуудын дараа хүмүүс буруу сургаал зааж эхэлснийг тайлбарла. Урвалтыг товчхон тайлбарлаад уг байгууламжийг нураа. Сүмийг сэргээх Иосеф Смитийн дуудлагын талаар ярилцаад, байгууламжийг дахин барихдаа хүүхдүүдийн дурдсан сургаалууд болон удирдах байр суурийг давтан хэл. Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Сүмийн Сэргээлтийн тухай гэрчлэлээ хуваалц.

Нэгдүгээр долоо хоногийн үзүүлэнт хичээлд дурдсан шаардлагатай материалууд танд нарт байхгүй бол өөрсдийн гарын доорх материалуудыг ашигла.



Хоёрдугаар долоо хоног: Би баптисм ба баталгаагаар дамжин сүмийн гишүүн болдог

Сургаалыг таньж мэд (зургуудыг үзэх): Сэтгүүлч болж жүжиглэ. “Сайхан мэдээний сүлжээнд тавтай морил! Өнөөдөр надад та бүхэнд мэдээлэх хамгийн гайхалтай мэдээ байна. Та нар бүгдээрээ Есүс Христийн үнэн Сүмийн гишүүд болж чадна! Энэ бол та нарын амьдралдаа хийж чадах хамгийн чухал зүйлсийн нэг мөн. Та баптисм (хүүхэд баптисм хүртэж байгаа зургийг харуул) болон баталгаагаар (хүүхэд батлуулж байгаа зургийг харуул) дамжуулан Сүмийн гишүүн болно” гэж хүүхдүүдэд хэл.

Ойлголтыг нь урамшуул (судруудыг унших): Хүүхдүүдийг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрд дараах асуултууд болон тохирох судруудаас нэг эсвэл түүнээс олныг өг. Хэрэв сэтгүүлч тэднээс эдгээр асуултуудыг асуусан бол тэд юу гэж хэлэх байсныг төсөөлөхийг хүс. Судруудаас хариултуудыг олохыг тэднээс хүс.

1. Би яагаад баптисм хүртэх ёстой вэ? (Иохан 3:5; Үйлс 2:38-ыг үзнэ үү.)
2. Би хэдэн настайдаа баптисм хүртэж болох вэ? (С ба Г 68:27-г үзнэ үү.)

3. Надад хэн баптисм хүртээж болох вэ? (С ба Г 20:73-ыг үзнэ үү.)
4. Би баптисм хэрхэн хүртэх ёстой вэ? (С ба Г 20:74-ийг үзнэ үү.)
5. Баптисм юуг бэлэгддэг вэ? (Ром 6:3–5-ыг үзнэ үү.)
6. Би баптисмд хэрхэн бэлтгэх вэ? (Алма 7:15–16; 19:35-ыг үзнэ үү.)
7. Би баптисм хүртэхдээ юу амладаг вэ? (Мозая 18:10-ыг үзнэ үү.)
8. Би Ням гараг бүр ариун ёслолоос хүртэж, баптисмын гэрээгээ шинэчлэхдээ юу амладаг вэ? (С ба Г 20:77-г үзнэ үү.)

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (асуултуудад хариулах): Хүүхдүүдээс ярилцлага авч байгаагаар жүжиглэ. Хүүхдүүдийг хэрхэн Сүмийн гишүүн болдог тухай сурсан зүйлээ мэдээлэхийг хүс.



Гуравдугаар долоо хоног: Ариун Сүнс намайг тайтгаруулж мөн хөтөлдөг

Сургаалыг танин мэдэж, ойлголтыг нь урамшуул (*гэрчлэлүүдийг сонсох*): Хүүхдүүдийг “Ариун Сүнс намайг тайтгаруулж мөн хөтөлдөг” хэмээн шивнэн хэлэхийг хүс. Нэг багшаас Ариун Сүнс түүнийг тайтгаруулж, хөтөлсөн үеийн тухай товч хуваалцахыг хүс.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (*дуу дуулах*): Хүүхэд бүрд хуудас цаас өгч, Ариун Сүнс хэрхэн тэднийг тайтгаруулж, хөтөлдөг тухай бодоход тэдний санаанд орж ирж буй цөөн

үгсийг бичихийг хүс. “Ариун Сүнс” (*ХДН*, 105) дууллыг дуулах үедээ бичсэн үгсээ олж сонсохыг хүүхдүүдээс хүс (*Сүмийн дуулал*, по. 143). Дуулах үедээ сонссон үгсээ дугуйлахыг тэднээс хүс. Хүүхдүүдийг дугуйлсан үгсээ хуваалцахыг уриад, үг бүр юу гэсэн утгатай болохыг ярилц. Та дугуйлаагүй үгсийг хуваалцуулахаар хүүхдүүдийг урьж болно. Хэдэн хүүхдээс Ариун Сүнс тэдэнд тайтгарал мөн удирдамж авчирсан үеүдийнхээ талаар ярихыг хүс.



Судрууд: Сайн мэдээний үнэнийг судруудаас суралцах нь хүүхдүүдийн хувьд маш чухал билээ. Судруудаас уншиж байх үед анхаарлаа төвлөрүүлж, сайн сонсоход нь хүүхдүүдэд тусал. Таныг судрын хэсгээс уншиж байхад бага насны хүүхдүүд ч гэсэн тодорхой ганц хоёр үгсийг сонсож чадна.

Дөрөвдүгээр долоо хоног: Би Ариун Сүнсний хүчээр үнэнийг мэдэж чадна

Сургаалыг таньж мэд (*үнэнийг худлаас ялгаж*): Хуудас цааснууд дээр тус тусад нь “Нар бол дулаан,” “Мөс бол халуун,” “Одод шөнөөр гэрэлтдэг,” “Гал бол хүйтэн” гэх зэрэг) гарцаагүй үнэн болон мэдээжийн худал мэдээллүүдийг бич. Нэг хүүхдийг нэг цаас сонгон чангаар уншихад урь, тэгээд уг мэдээлэл үнэн бол босож зогсохыг, худал бол суухыг хүүхдүүдээс хүс. “Чи яаж мэдэж байгаа юм бэ?” гэж асуу. Цаас бүр дээр үүнийг давт. Бид ямар нэгэн зүйл үнэн гэдгийг мэдэж чадах өөр нэг арга зам бол Ариун Сүнсний хүчээр гэдгийг тайлбарла. Моронай 10:5-ыг унш.

Ойлголтыг нь урамшуул (*судруудыг унших*): Бид Ариун Сүнсний хүчээр үнэнийг мэдэж чадна; бид Сүнсний дуу хоолойг сонсох юмуу оюун ухаан болон зүрх сэтгэлдээ Түүний ярихыг мэдэрч болно гэдгийг тайлбарла. Толгой (оюун ухаан), зүрх ба чихийг дүрсэлсэн зургуудыг үзүүл (загвар зургуудыг sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно). Хүүхдүүдийг дөрвөн бүлэг болгон хувааж, бүлэг бүрийг дараах судруудаас нэгийг бүлгээрээ чангаар уншихыг хүс (“Найрал дууны заалтууд,” *TNGC*, 163-ыг үз): С ба Г 11:13, Хиламан 5:45, С ба Г 8:2, Хиламан 5:46–47. Бүлэг бүрийг судраа унших үед аль зураг нь уг судартай тохирохыг толгой, зүрх эсвэл чихэндээ хүрч харуулахыг бүх хүүхдээс хүс.



Сайн мэдээний тухай суралцах үед тэдний мэдэрдэг хайр болон амар амгалангийн мэдрэмжүүд нь Ариун Сүнснээс ирдэг болохыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Энэ нь биеллээ олж болохын тулд бишрэл хүндэтгэлтэй, тайван уур амьсгалыг бүрдүүлсэн байхад анхаараарай.



Хөгжим: Хичээл зааж байхдаа Хүүхдийн хэсгийн дуунуудыг ашигла. Энэ нь хүүхдүүдэд заалгасан зүйлээ санахад тусална. “Удаан сурах зарим сүнслэг зүйлсийг . . . дуу хөгжмөөр дамжуулан маш хурдан сурч, мэдрэх чадвар бидэнд байдаг” (Бонд К.Пакэр, *TNGC*, 46).

Үр бүтээлтэй үйл ажиллагаануудад оролцох нь гэр бүлийг бэхжүүлнэ

Дуу: “Их Эзэнийг эрэлхийл” (ХДН, 108)

“Аз жаргалтай. . . гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна” (“Гэр Бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: “[Гэр бүл] чинь адислагдаж болохын тулд гэр бүлдээ Эцэгт хандан . . . залбир” (3 Нифай 18:21)

Сургаалыг таньж мэд (зураг үзэх ба судар цээжлэх): Есүс Христийн зургийг харуулаад Тэрээр “[Гэр бүл] чинь адислагдаж болохын тулд гэр бүлдээ Эцэгт хандан . . . залбир” (3 Нифай 18:21) хэмээн заасныг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдтэй хамт уг судрыг цөөн хэдэн удаа давт. Нэгэн гэр бүлийн залбирч байгаа зургийг үзүүлээд уг зургийн талаар хүүхдүүдтэй ярилц. Гэр бүлийн залбиралдаа бид адислалуудынхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлж мөн гэр бүлүүдэд маань тусалж, адислахыг Түүнээс гуйдаг гэдгийг тайлбарла.

Ойлголтыг нь болон сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (дуулах ба санал бодлоо хуваалцах): Хүүхдүүдийг нэг болон түүнээс дээш тойрог болж зогсохыг хүс. “Тэр бүлийн залбирал” (ХДН, 189) дууллыг дуул. Хүүхэд бүрийг гэр бүлийнхээ залбиралд Тэнгэрлэг Эцэгт талархах эсвэл гуйх ямар нэгэн зүйлийг хуваалцахад урь, тэгээд тойрог дотор байгаа өөр нэг хүүхэдтэй гар гараа барилцаж зогсохыг хүс. Бүх хүүхдүүд гар



Хүүхдийн хэсгийн хичээлийн дундуур хөдөлгөөнтэй үйл ажиллагаа хийх нь тэдний идэвх оролцоог сайжруулж, соргог байлгадаг. Хүүхдийн хэсгийнхээ хэрэгцээнээс хамаарч, үйл ажиллагаануудыг өөрчил.

гараасаа барилцаж дуусахад, гэр бүлийн залбирлаар дамжуулан гэр бүлүүд хэрхэн нэгдэж, адислагдаж мөн хүчирхэгждэгийг цохон тэмдэглэ.

Хоёрдугаар долоо хоног: Гэр бүлийн үдэш гэр бүлийг маань бэхжүүлдэг

Сургаалыг таньж мэд (сургаалыг давтах): Хүүхдийн хэсгийг гурван бүлэгт хуваа. Бүлэг бүрээс нэг хүүхдийг гаргаж дараах үгсийг бичсэн цаасыг барихад урь, тэгээд тухайн бүлгийн хүүхдүүдийг бүлэгт нь хуваарилсан тэдгээр үгсийг хамтдаа уншихыг хүс.

Ойлголтыг нь урамшуулан дэмж (хүчирхэг гэр бүлүүдийг төсөөлөх): Ерөнхийлөгч Иосеф Ф.Смитийн зургийг харуулаад 1915 онд тэрээр гэр бүлийн үдшийг эхлүүлсэн бөгөөд гэр бүлийн үдшийг тогтмол хийснээр ирэх “агуу адислалуудыг” амласан болохыг тайлбарла. Одоогийн бошиглогчийн зургийг үзүүлээд, эдүгээ бараг 100 жилийн дараа ч гэр бүлийн үдэш нь гэр бүлүүдийг бэхжүүлдэг гэсэн гэрчлэлийг бошиглогч хуваалцсан хэвээрээ байгааг тайлбарла. Нэгэн гэр бүлийг төлөөлж, хэдэн хүүхдээс гар гараасаа барилцан хамтдаа зогсохыг хүс. Нэг хүүхдээр тэдний нэгийг бусдаас нь холдуулахын тулд татуул. Гэр бүлийн үдшээ хийх үедээ гэр бүлүүд хүчирхэг байдаг гэдгийг тайлбарла.



ГЭР БҮЛИЙГ МААНЬ



“Гэр Бүлийн “Гэр Бүлийг Маань” “Бэхжүүлдэг” Үдэш”

Бичсэн үгсийг хүүхдүүдээр хооронд нь солиулж, бүх бүлгүүд эдгээр үгсийг хэлэх хүртэл уг үйл ажиллагааг давтан хий.

Судруудыг цээжлэх нь хүүхдүүдэд сайн мэдээний сургаалыг суралцахад нь тусалдаг. Сүнс хэрэгцээтэй цагт эдгээр үгсийг санахад нь хүүхдүүдэд амьдралынх нь туршид туслах болно.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (гэр бүлийн үдэш хийж байгаагаар жэжигжилсэн тоглолт хийх): Гэр бүлийн үдшээрээ юу хийхийг хүсэж байгаагаа хуваалцахад нь хэдэн хүүхдийг

урь. Тэдний санал бодлыг самбарт бич. Гэр бүлийн үдшээ төлөвлөж, хувь нэмрээ оруулахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Гуравдугаар долоо хоног: Судар судлах нь надад болон гэр бүлд маань сүнслэг хүч чадлыг өгдөг

Сургаалыг таньж мэд (асуултуудад хариулах): Гарынхаа булчинг чангалж, биеийнхээ хүч чадлыг харуулахыг хүүхдүүдээс хүс. Бие махбодын хувьд илүү хүчирхэг болохын тулд тэд юу хийж чадахыг асуу. Судруудаа өргөөд, судруудыг судалснаар бидний сүнс илүү хүчирхэг болж чадна гэдгийг тайлбарла. Таныг судруудаа дээш өргөх болгонд хүүхдүүдийг “судар судлах” гэж хэлэхийг хүс. Энэ үгээр хариулж болох хэдэн асуултуудыг асуу, жишээлбэл: “Сайн бодол санаатай байхад надад юу тусалж чадах вэ?” болон “Би зөвийг сонгох хүч чадлыг хэрхэн олж авах вэ?” Хариулахад нь хүүхдүүдэд туслах үүднээс асуулт бүрийн дараа судраа дээш өргө. (Хэрэв хүүхдүүд Хүүхдийн хэсэгт ирэхдээ судруудаа авчирдаг бол таны асуултад “судар судлах” гэж хариулах үедээ өөрсдийнхөө судруудыг дээш өргөхийг тэднээс хүс.)

Ойлголтыг нь урамшуулан дэмж (судрын түүхийг хэлэлцэх): Матай 4:1–11 дэх Есүс Христийн соригдсон арга замуудыг төлөөлөх гурван зургийг самбар дээр байрлуулж бэлтгэ. Зураг бүрийн доор тохирох судрын эшлэлийг бич (Матай 4:4, Матай 4:7 ба Матай 4:10). Есүс Христ соригдох үедээ судруудыг ашигласан болохыг тайлбарла. Матай 4:1–11-ийг чангаар уншаад, сорилт бүрийн дараа хэсэг зогсож “Юу Есүст сүнслэг хүч чадал өгсөн бэ?” хэмээн асууж тодруул. Хүүхдүүдэд хариулахад нь туслахын тулд



судруудаа өргөж, Есүс Христийн хэлсэн хариултыг судруудаас уншихыг нэг хүүхдээс хүс. “Бичигдсэн байдаг” гэдэг нь Есүс судраас эш татаж байгаа болохыг тайлбарла.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (судар цээжлэх): Судруудаас тэдэнд мөн гэр бүлүүдэд нь сүнслэг хүч чадлыг өгч чадах нэг богино судрын эшлэлийг хамтдаа цээжлэхийг анги бүрээс хүс (жишээ нь: Лук 1:37, 1 Нифай 3:7 эсвэл С ба Г 10:5).

Дөрөвдүгээр долоо хоног: Хүндэтгэлийн өдөр бол амрах ба шүтэн бишрэх өдөр мөн

Сургаалыг таньж мэд (үгсийг тайлж унших): Дараах өгүүлбэр дэх үгсийг есөн хуудас цаасан дээр тус тусад нь бичээд дугтуйнд хийж анги болгонд өг: *Хүндэтгэлийн өдөр бол амрах ба шүтэн бишрэх өдөр мөн.* Эдгээр үгсийг зөв дараалалд оруулахыг тэднээс хүс. “Амрах” ба “шүтэн бишрэх” гэсэн үгсийн утгыг ярилц. Холбоо үгсийг давтан хэл.

Хүндэтгэлийн өдөр бол амрах ба шүтэн бишрэх өдөр мөн.

Энд дарж цаасан дээрх үгс рүү орно уу

Ойлголтыг нь урамшуулан дэмж (судруудыг хэлэлцэх): Самбарт дараах судрын эшлэлүүдийг бич: Египетээс гарсан нь 20:8–11; Лук 23:56; Мозая 18:23; Сургаал ба Гэрээ 68:29. Тэнгэрлэг Эцэг дэлхийг зургаан өдөрт бүтээж (гарынхаа зургаан хурууг дээш өргөн хөдөлгөнө), харин долоо дахь өдрөө Тэрээр амарсан бөгөөд (гарынхаа долоон хурууг дээш өргөн барина), бүх цаг үеийн туршид Тэрээр Өөрийн хүүхдүүдийг долоо дахь өдөр буюу Хүндэтгэлийн өдрөөр амарч, үүнийг ариунаар нь сахицыг тушаасан болохыг тайлбарла. Самбарт бичсэн судруудыг уншуулахаар дөрвөн хүүхдийг урь. Ямар зарчим заагдаж байгааг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Эдгээр

судрууд нь дэлхийн түүхийн өөр өөр цаг үед бичигдсэн боловч бүгд нэг ижил зарчмыг заадаг болохыг онцол. Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахиж гэдэг нь биднийг Тэнгэрлэг Эцэгт ойртуулах зүйлсийг хийнэ гэсэн үг болохыг тайлбарла.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (тоглоом тоглох): Хүүхдүүдээр даваа гарагаас эхлүүлэн долоо хоногийн бүх өдрүүдийг тоолуул. “Ням гараг” гэж хэлэх хүүхдээс Хүндэтгэлийн өдөр хийж болох нэг зөв зохистой үйл ажиллагааг санал болгохыг хүс. Цаг байвал үргэлжлүүлэн хий.

Судрууд: Зарим хүүхдүүд сударгүй байж магадгүй. Зарим нь уншиж сураагүй байж мэднэ. Судруудаас суралцахдаа бүх хүүхдүүдийг хамруулах арга замуудыг бодож ол. Жишээлбэл: Та судрыг самбарт бичээд хамтдаа уншиж болно эсвэл нэг судрыг хэсэг бүлгээр нь хуваалцуул.

Сайн мэдээгээр амьдрах нь гэр бүлийг адисалдаг

Олон янзын арга:

Судрууд болон хэлц үгсийг хүүхдүүдтэй хамт давтахдаа олон янзын арга ашиглаарай. Жишээ нь: Та охид, хөвгүүдээс хэлц үгсийг тус тусдаа давтан хэлэхийг, хэлэхдээ чангаар эсвэл намуухнаар хэлэхийг хүсч болно.



“Шударга, үнэнч, ариун явдалтай, нинжин сэтгэлтэй, ач буянтай байхад мөн бүх хүмүүст сайн сайхныг үйлдэхэд бид итгэдэг; чухамдаа—Бид бүх зүйлд итгэдэг, бид бүх зүйлд найддаг, бид олон зүйлийг хүлцэн тэвчлээ, мөн бүх зүйлийг хүлцэн тэвчих болно гэдэгт найддаг гэсэн Паулын зөвлөгөөг бид дагадаг хэмээн хэлж болно. Хэрэв ариун журамтай, сайхан, эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйл байдаг бол бид эдгээр зүйлүүдийг эрэлхийлдэг” (Итгэлийн Тунхаг 1:13).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Би бүх адислалуудынхаа төлөө баярласнаа илэрхийлснээр талархлаа харуулдаг

Сургаалыг таньж мэд (түүх сонсох ба судар унших): Уяман өвчтэй арван хүний түүхийг товчхон ярь (Лук 17:11–19-ийг үзнэ үү). Уг түүхэнд хэн нь талархлаа илэрхийлснийг хүүхдүүдээс асуу. Сургаал ба Гэрээ 59:7-г уншаад бид хэнд талархал илэрхийлэх ёстойг мөн юуны төлөө Түүнд талархал илэрхийлэх ёстойг хүүхдүүдээс асуу.

Ойлголтыг нь болон сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (тоглоом тоглох): Гэр бүл, найзууд, хоол хүнс, гэр, дэлхий, амьтад ба

ариун сүмүүд зэрэг адислалуудыг дүрсэлсэн зургуудыг гаргаж харуул. Хүүхдүүдийг нүдээ анин “Тэнгэрлэг Эцэгтээ талархъя” (ХДН, 20) дууллыг дуулахыг хүсээд энэ хооронд нь зургуудаас нэгийг нь буцааж далд хий. Дуугаа дуулж дуусахад нь тэднийг нүдээ нээхийг хүсээд аль зураг нь алга байгааг олж чадах эсэхийг хар. Нэг хүүхэд рүү чихмэл тоглоом шидээд, тэрхүү адислалын төлөө тэд хэрхэн талархлаа илэрхийлж чадахыг хуваалцахыг хүс Цаг байвал үргэлжлүүлэн хий.

Хоёрдугаар долоо хоног: Би бусдад үйлчилснээр Бурханд үйлчилдэг

Сургаалыг таньж мэд (судар унших): Дараах үгсийг самбарт бич: Би бусдад _____ Бурханд _____ байгаа юм. Мозая 2:17-г хамтдаа уншаад, уг хоосон зайнд ямар үг тохирохыг хүүхдүүдээс асуу (үйлчилснээр, үйлчилж). Уг хэлц үгийг давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг нь урамшуулан дэмж (түүх сонсох): Дараах түүхийг хуваалц: “Ерөнхийлөгч Хибэр Ж. Грантыг төрөөд дөнгөж ес хонож байхад аав нь нас баржээ. Түүний ээж маш ядуу байсан бөгөөд тэрээр хүмүүст хувцас оёж өгөн, мөнгө олдог байв. Заримдаа тэр ямар ч амралтгүйгээр, оёдлын машиныхаа дөрөөг ч гишгэж дийлэхгүй болтлоо олон цагийн турш юм оёдог байлаа.



Хүүхдийн хэсэгт хуваалцдаг түүхүүдийг хүүхдүүдээр дүрслэн үзүүлэхэд анхаар.

Хибэр байнга оёдлын машинынх нь доогуур мөлхөн ороод, дөрөөг нь гишгэн өгч түүнд тусалдаг байв. Өвлийн улирал маш хүйтэн байсан бөгөөд өөрийг нь дулаан байлгах ганц нимгэн хуучин хүрэм л Хибэрт байлаа. Тэр дулаан хүрэмтэй болохыг удаан хугацаанд хүссэн хэдий ч тэд зөвхөн хоолонд л арай хийж хүрэлцэх мөнгөтэй гэдгийг мэдэж байв. Ээж нь түүнд төрсөн өдрөөр нь өөрийн оёсон дулаан хүрмийг бэлэглэхэд тэр их баярлажээ. Хүрэм нь түүнд байсан хамгийн үнэтэй зүйл байв. Хэдэн долоо хоногийн дараа Хибэр хүйтэнд дагжин чичирч байгаа нэгэн хүүг хараад даарах нь ямар байдгийг саналаа. Тэр шинэхэн хүрмээ тайлаад тэр хүүд өгчээ.” Та мөн www.mormonchannel.org/the-coat хуудсан дээр байгаа

“Хүрэм” видеог үзүүлж болно. Хибэр хэрхэн бусдад үйлчилсэн тухай ярилцаад, цөөн хэдэн хүүхэд болон багш нарыг үйлчлэлтэй холбоотой өөрсдийн туршлагаадаа хуваалцахад урь. Бид

бусдад үйлчлэхдээ Бурханд үйлчилдэг тухай ярилц. (Харилцан яриаг сайнаар өрнүүлэхэд тус болох асуултуудыг хэрхэн асуух тухай санаануудыг авах бол TNGC, 68–70-ыг үз.)

Гуравдугаар долоо хоног: Бид шударга байхад итгэдэг

Сургаалыг таньж мэд (түүх сонсох ба судрыг цээжээр хэлэх): Загас барихаар аялалд явсан нэг хүүхэд барьсан загасныхаа хэмжээг өөр нэг хүүхэд хэтэрхий дэгсдүүлэн хэлсэн тухай түүхийг ярь. Уг хүүхэд ямар буруу зүйл хийснийг мөн тэр юу хийх ёстой байсныг хүүхдүүдээс асуу. Үнэнийг хэлэхэд нь тэдэнд туслах Итгэлийн Тунхагуудын нэгийг бодохыг хүүхдүүдээс хүс. Итгэлийн арван гурав дахь тунхгийн эхлэлийг хамтдаа давтан хэл (“Бид шударга байхад итгэдэг”).

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (нөхцөл байдлуудад хариулах): Эцэг эх нь шалан дээрхэн тоглоомоо үлдээснийг асуух зэрэг хүүхдүүд шударга бус байхаар уруу татагдаж болох нэг нөхцөл байдлыг танилцуул. Тэд шударга байхын тулд юу хийх чадахаа мэдэж байгаа бол босож зогсохыг хүүхдүүдээс хүс. Цөөн хэдэн хүүхдээр хариултуудыг нь хуваалцуул. Цаг үлдвэл өөр нөхцөл байдлууд дээр үүнийг давт. Шударга бус байхаар уруу татагдах үедээ “Бид шударга байхад итгэдэг” гэсэн үгсийг бодоход нь хүүхдүүдийг урамшуул.




Түүхүүд: Түүх ярьж өгөх нь хүүхдүүдийн анхаарлыг татаж, сайн мэдээний зарчмуудыг тэдэнтэй холбоход тусалдаг. Тэдэнтэй хуваалцахдаа царайны хувирал болон сэтгэлийн хөөрлөө гаргаж, өөрийнхөө үгээр илэрхийлэхийн тулд түүхүүдээ сайтар судлаарай.

Дөрөвдүгээр долоо хоног: Би сайн мэдээгээр амьдарснаар бусдад сайн үлгэр жишээ үзүүлдэг

Сургаалыг таньж мэд (түүхийг үйлдлээр үзүүлэх): Дараах түүхийг ярьж, үүнийг тантай хамт үйлдлээр үзүүлэхэд хүүхдүүдийг урь: “Хүчтэй цасан шуурга болж байхад чи гэр бүлийнхээ хамт ууланд аялж байсан (чичирнэ). Чи буудалласан газраа буцаж очих замаа харж чадахгүй байв (гараа нүдэн дээрээ тавиад, зүг чихайна). Тэгтэл аав чинь том, хүнд түрийтэй гутал өмсөж ирээд (алхаж явна) Тэрээр ‘Би замаа мэднэ! Намайг дагаад яв!’ гэжээ. Аав чинь чамд зориулж өөрийг нь дагах том хөлний мөрийг цасан дээр үлдээж байв.” Яг л бид аавынхаа хөлний мөрийг дагаж явж чадсан шиг биднийг сайн мэдээгээр амьдрах үед бусад хүмүүс бидний сайн үлгэр жишээг харж, дагаж чаддаг гэдгийг тайлбарла. “Би сайн мэдээгээр амьдарснаар бусдад

сайн үлгэр жишээ үзүүлдэг” гэж таныг хэлэхэд давтаж хэлэхийг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг нь болон сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (судар унших ба жишгүүдийн талаар ярилцах): Хүүхдүүдээр 1 Тимот 4:12-ыг уншуул. Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос хүүхдүүдэд тохиромжтой гэж бодсон зарим жишгүүдийг хуудас цааснууд дээр тус тусад нь бичээд нэг саванд хий. Нэг хүүхдийг эдгээр жишгүүдээс нэгийг сугалаад уг жишигтэй холбоотой хувийн туршлага эсвэл энэхүү жишгээр амьдрах нь бусдад хэрхэн сайн үлгэр жишээ үзүүлдэг тухай хуваалцахыг хүс. Энэ мэтээр бусад жишгүүд дээр ажилла. “Би сайн мэдээгээр амьдрахыг хүсэж байна” (ХДН, 148) дууллыг дуул.



“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” нь гэр бүлд туслахаар Бурханаас ирсэн

“Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв” (Иохан 15:11).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Нэгдүгээр долоо хоног: “Гэр Бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” нь гэр бүлд туслахаар Бурханаас ирсэн

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдэд Арван Зарлигийг болон судруудыг харуулсан зураг үзүүл. “Эдгээр нь хаанаас ирсэн бэ?” гэж асуу. Эдгээр нь бидэнд юу хийхээ мэдэхэд туслахын тулд бошиглогчдоор дамжуулан Бурханаас ирсэн болохыг тайлбарла. “Гэр Бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” бичгийн нэг хувийг хүүхдүүдэд харуулаад, энэхүү зүйл нь бидний гэр бүлүүдэд туслахын тулд Хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан Бурханаас ирсэн гэдгийг тайлбарла.

Ойлголтыг нь урамшуулан дэмж (дуу дуулах): Бүх гэр бүлүүд адил биш хэдий ч гэр бүл

болгон чухал ба Бурхан бүх гэр бүлийг аз жаргалтай байж, Түүн рүү буцаж очихыг хүсдэг болохыг тайлбарла. Гэр бүлийн тунхгаас өөр өөр өгүүлбэрүүдийг бичсэн хэдэн цаасан туузыг анги бүрд өг. Тэдний авсан өгүүлбэртэй холбогдох нэг дууг бодож олохыг хүүхдүүдээс хүс. Ангиудыг ээлж ээлжээр цаасан туузаа чангаар уншиж, сонгож авсан дуугаа бусад хүүхдүүдийг удирдан дуулахад урь. Гэр бүлүүд Гэр бүлийн тунхаг дахь сургаалуудыг дагаснаар адислагдах болно гэдгийг гэрчил.

Хоёрдугаар долоо хоног: Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханы төлөвлөгөөнд амин чухал

Ойлголтыг нь урамшуулан дэмж (түүх сонсох ба ярих): Дэлхий дээрх анхны хүн нь Адам байсан тухай түүхийг ярь. Эхлэл 2:18-ыг нэг хүүхдээр уншуулж, Тэнгэрлэг Эцэг юу гэж хэлснийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс (“Хүн ганцаараа байх нь сайн биш”). Адамтай гэрлүүлэхийн тулд Тэрээр Еваг бүтээснийг тайлбарла. Нэг хүүхдээр Эхлэл 3:20-ийг уншуулж, Адам эхнэрээ хэн гэж нэрлэснийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс (Ева). Дараа нь нэг хүүхдээр Эхлэл 1:28-ыг уншуулаад Тэнгэрлэг Эцэг Адам, Ева хоёрт юу гэж тушаасныг олж сонсохыг хүс (“өсөн нэмэгд” буюу гэр бүлтэй бол). Адам Ева

хоёрын гэрлэлтгүйгээр Түүний хүүхдүүдийн дэлхий рүү ирэх Бурханы төлөвлөгөө биелэхгүй байх байсныг тайлбарла. Хэдэн хүүхдийг уг түүхийг дахин ярихад урь.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (зургуудыг үзэх): Эрэгтэй эмэгтэй хүмүүс гэрлэж, гэр бүлтэй болох Тэнгэрлэг Эцэгийн зарлиг нь Адам Ева хоёрыг дэлхий дээр байх үед чухал байсны адилаар өнөөдөр ч гэсэн чухал байгааг тайлбарла. Гэр бүлүүдийн зургийг үзүүлж, хүүхдүүдээр зураг дээрээс эрэгтэй, эмэгтэй хүн болон хүүхдүүдийг заалгуул.

Гуравдугаар долоо хоног: Гэр бүлийн амьдрал Есүс Христийн заасан сургаал дээр суурилах үед бид аз жаргалтай байж чадна

Сургаалыг таньж мэд (зургуудыг үзэх): Нэгэн гэр бүлийн зургийг бариулахаар нэг хүүхдийг урь. Бид аз жаргалтай байж болохын тулд гэр бүлийн амьдрал маань юун дээр суурилах ёстойг асуу. Есүс Христийн зургийг бариулахаар өөр нэг хүүхдийг урь. Гэр бүлийн амьдрал Есүс Христийн заасан сургаал дээр суурилах үед бид аз жаргалтай байж чадна гэдгийг тайлбарла.



Ойлголтыг нь болон сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуул (*жагсаалт гаргах*): Есүс Христийн зургийг самбар дээр байрлуулж үүний доор “Есүсийн заасан сургаалууд” гэж бич. Хүүхдүүдийг гурван бүлэг болгон хуваарил. Бүлэг бүрд дараах судрын эшлэлүүдийг бичсэн цаасан туузнуудаас нэгийг өг: “Тушаалуудыг сахь” (Иохан 14:15), “Бусдад тусал” (Мозая 2:17) ба “Хүн бүрд хайраа харуул” (Иохан

13:34). Хуваарилж авсан судраа уншиж, Есүсийн заасан сургаалуудыг гэр бүлдээ дагах арга замуудыг бүлэг дотроо ярилцахыг хүүхдүүдээс хүс. Бүлэг бүрийг цаасан туузаа самбар дээр тогтоож, ярилцсан зүйлээ бусад хүүхдүүдтэй хуваалцахад урь. Бүлэг бүр өөрсдийн санаагаа хуваалцсаны дараа Есүсийн сургаалыг дагах нь гэр бүлүүдийг аз жаргалтай байхад хэрхэн тусалж чадах талаар ярилц.



Түүхийг дахин яриулах: Хүүхдүүд дөнгөж сая сонссон түүхээ эргүүлэн ярихдаа үүнийг илүү сайн санах болно.



Судрууд: Хүүхдүүдийг өөрсдийнх нь судруудаас уншуулах нь судруудын ач холбогдлыг ойлгуулж, Сүнснийг урьдаг. Боломжтой бол хүүхдүүдийг судар дээрээ тэмдэглэгээ хийж, хамтдаа уншихыг хүс.


Дөрөвдүгээр долоо хоног: Амжилттай гэр бүлүүд хамтдаа ажилладаг

Сургаалыг таньж мэд (*үзүүлэнт хичээлд оролцох*): Ангийн урд дөрвөн хүүхдийг гарч ирэхийг урь. Хүүхэд тус бүрд нэг нэг уяаны үзүүр бариулаад эдгээр дөрвөн уяаны нөгөө үзүүрээс нь өөрөө барь. Хүүхдүүдийг уяануудаа эргүүлж, олс болгохоор хамтран ажиллахыг хүс. Хамтдаа эргүүлэх нь уяануудыг бат бөх олс болгосон шиг хамтдаа ажиллах нь гэр бүлийг хүчирхэг болгодгийг онцлон хэл. Дараах үгсийг цаасан туузнууд дээр тус тусад нь бич: *Амжилттай, гэр бүлүүд, хамтдаа, ажилладаг*. Цаасан туузнуудыг олсонд бэхэл. Өгүүлбэрийг хамтдаа уншихыг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг нь урамшуулан дэмж (*жүжигчилсэн тоглолт хийх*): Ноагийн зургийг харуулан, Ноа үерт бэлтгэхийн тулд хэрхэн хөвөгч авдар барьж, амьтдыг цуглуулсан тухай түүхийг товчхон ярь (Эхлэл 6–7; Мосе 8-ыг үз). Хүүхдүүдийг бүлгүүдэд хуваарилж, бүлэг тус бүрээс Ноагийн гэр бүл хамтдаа ажилласан байж болох (хөвөгч авдарт хоол хүнс цуглуулж хийх, хөвөгч авдрыг барих болон амьтдыг цуглуулах гэх мэт) нэг арга замыг жүжигчлэн харуулахыг хүс. Тэдний юу хийж байгааг таахыг бусад хүүхдүүдээс хүс. Ноагийн гэр бүл хамтдаа ажилласан учраас амжилттай байсныг тайлбарла.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул

(*зураг зурах*): Яг л Ноагийн гэр бүл хамтдаа ажилласан шиг гэр бүл дотроо хамтдаа ажиллах нь бидний хувьд чухал болохыг тайлбарла. Хүүхэд бүрд хуудас цаас болон өнгийн харандаанууд өгөөд гэр бүлээрээ хамтдаа ажиллаж байгаагаа зурахыг хүс. Хэдэн хүүхдийг зурсан зургаа бусадтайгаа хуваалцаж, уг зүйлийг хийх нь тэдний гэр бүлүүдийг амжилттай байхад нь хэрхэн туслахыг тайлбарлаж өгөхийг хүс.




Үзүүлэнт хичээлүүд нь “үл үзэгдэх санааг . . . суралцагсдын сайн мэдэх бодит зүйлтэй холбон, мэдлэгийг үндэслүүлдэг” (Бонд К.Пакэр, TNGC, 163).



Есүс Христийн сургаалаар амьдрах нь намайг болон гэр бүлийг маань бэхжүүлдэг

“Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно” (“Гэр Бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**



Нэгдүгээр долоо хоног: “Хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах болно” (Алма 32:21)

Сургаалыг таньж мэд (судар цээжлэх): Самбар дээр “Хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах болно” гэж бич. Хүүхдүүдээр үүнийг хэдэн удаа чангаар уншуулаад дараа нь үг бүрийн эхний үсгүүдээс бусдыг нь арилга. Үүнийг дахин цээжээр хэлэхийг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүд уг судрыг бүрэн цээжилж дуусах хүртэл үсгүүдийг нэг нэгээр нь арилга.


Ойлголтыг нь урамшуул (судрын түүх сонсох): Шөнө болсон гэдгийг хүүхдүүд хэрхэн мэддэгээ дүрслэхийг тэднээс хүс. Лемен

үндэстэн Самуелын зургийг харуулж, тэрээр Есүс Христийн төрөх өдөр нар шингэх хэдий ч харанхуй болохгүй хэмээн бошиглогсныг тайлбарла. Хүүхдүүдээр Хиламан 16 ба 3 Нифай 1:1–13 дахь уг үйл явдлыг дахин яриул (та энэхүү түүхийг хуваалцахаар урьдчилан бэлтгэхийг хэдэн хүүхдээс хүсэж болно). Цээжилсэн судраа уншихыг хүүхдүүдээс хүсээд нифайчуудын итгэгчид хэрхэн итгэлээ харуулсныг тэднээс асуу. Тэдгээр итгэгчдэд юу тохиолдсон гэж бодож байгааг нь хүүхдүүдээс асуу. Нэг хүүхдийг 3 Нифай 1:15, 19-ийг уншихыг хүс. Итгэлийн ач холбогдлын тухай гэрчил.

Хоёрдугаар долоо хоног: Залбирал бол Тэнгэрлэг Эцэгтэй харилцах бишрэл хүндэтгэлтэйгэй харилцаа мөн

Сургаалыг таньж мэд (эд зүйлс ба зургуудтай танилцах): Хүүхдийн хэсэг эхлэхээс өмнө (захиа, утас эсвэл компьютер зэрэг) хүмүүсийн харилцахдаа хэрэглэдэг зүйлсийн зургийг цуглуулах буюу зураад Хүүхдийн хэсгийн өрөөндэх сандлуудын доор нуу. Хүүхдүүдийг гэрээсээ

хол байгаа бөгөөд гэр бүлтэйгээ харилцах хэрэгтэй байгаагаар төсөөлөхийг хүс. Тэднээр сандлуудын доор нуусан зургуудыг олуулан, эдгээр зүйлс нь бусадтай харьцахад бидэнд хэрхэн тусалж чадахыг ярилц. Энэ дэлхийд ирэхдээ бид тэнгэрлэг гэрээ орхисон хэдий ч Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаж чадна гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс “Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хэрхэн харилцаж чадах вэ?” гэж асуу. Хүүхдүүд болон гэр бүлүүд залбирч байгаа хэд хэдэн зургийг тэдэнд харуул. Зураг болгон нь Тэнгэрлэг Эцэгт хандан —хайр хүндэтгэлтэйгээр залбирах— бишрэлтэй харилцааг харуулж байгааг тайлбарла. Хүүхдүүдээс “Залбирал бол Тэнгэрлэг Эцэгтэй харилцах бишрэлтэй харилцаа мөн” гэж хэлэхийг хүс.



Ойлголтыг нь болон сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (*самбар дээр хийх үйл ажиллагаа*): Залбирлын дөрвөн хэсгийг самбар дээр жагсаан бич. Тэнгэрлэг Эцэгт талархаж болох мөн Түүнээс гуйж болох зүйлсийг нэрлэхийг

хүүхдүүдээс хүс. Хариултуудыг нь самбар дээр жагсаан бич. Залбирах үедээ хүндэтгэл бишрэлээ хэрхэн харуулах ёстойг үзүүлэхийг хүүхдүүдээс хүс.

Гуравдугаар долоо хоног: Наманчлал бол оюун санаа болон зүрх сэтгэл дэх өөрчлөлт

Сургаалыг таньж мэд (*зургийг ил гаргах*): “Наманчлал бол оюун санаа болон зүрх сэтгэл дэх өөрчлөлт” гэсэн өгүүлбэрийн үг бүрийг тус тусад нь бичсэн цаасан туузуудыг бэлтгэ. Эдгээр цаасан туузуудаар Антай-Нифай-Лихайчууд зэвсгүүдээ газарт булж байгаа зургийг бүтээж далдал. Цаасан туузуудыг холдуулж, үгсийг зөв байрлалд оруулан, самбар дээр тогтоохыг хэдэн хүүхдээс хүс. Хүүхдүүдээс оюун санаа болон зүрх сэтгэл гэсэн үгсийг үйл хөдлөлөөр тодотгон, өгүүлбэрийг бүхэлд нь уншихыг хүс.

Ойлголтыг нь урамшуул (*судрын түүх сонсох*): Зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрсэн хэсэг бүлэг хүмүүс Мормоны номонд гардаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Дараах түүхийг ярь (Алма 24-ийг үз): “Аммон хэсэг бүлэг леменчүүдэд сайн мэдээний тухай заажээ. Тэд урд нь ёс бус

хүмүүс байсан боловч Аммоны тэдэнд заасан үгсэд итгэж, зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрсэн байна. Тэд Сүмд нэгдэхийг хүсэж байсан учраас гэм нүглүүдээ наманчилж, дахиж дайн тулаан хийхгүй хэмээн амлаж, өөрсдийн дайны зэвсгүүдээ газарт булшилжээ. Тэд нэрээ Антай-Нифай-Лихайчууд болгон өөрчилж, ажилсаг, зөв шударга хүмүүс болжээ.”

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (*“илднүүдээ” булшлах ба дуулах*): Хүүхэд бүрд нэг хуудас цаас өг. Хүүхдүүдээс илд зурж уг илдэн дээрээ бидний хийдэг нэг буруу сонголтыг (“ахтайгаа зодолдох” эсвэл “худлаа ярих” гэх мэт) бичихийг хүс. Хүүхдүүдээс зөвийг сонгож чадах арга замуудаа хуваалцан, цаасаа базаж хаяснаар өөрсдийн илднүүдээ “булшлахыг” хүс. “Наманчлал” (ХДН, 98) дууллыг дуул.

Дөрөвдүгээр долоо хоног: Өршөөл нь амар амгаланг авчирдаг

Сургаалыг таньж мэд (*үзүүлэнт хичээл харах*): Хэрэв хэн нэгэн өөрийг нь түлхэх эсвэл цохивол тэдэнд ямар санагдахыг хүүхдүүдээс асуу. Гартаа том чулуу бариад хүүхдүүдэд энэ нь тэдгээр гомдсон мэдрэмжүүдийг төлөөлж байгааг хэл. Тэгээд чулууг урт оймсон дотор хий. Нэг хүүхдийг ангийн урд гарч ирээд уг оймсыг хөлнийхөө шагай хэсэгт уяхад урь. Тэгээд уг хүүхдийг эргэн тойронд алхахыг хүс. Муухай мэдрэмжүүдийг дотроо тээж явах нь бидэнд хэрхэн ачаа дарамт болдгийг ярилц. Биднийг гомдоосон хүмүүсийг өршөөх үед тэдгээр муухай мэдрэмжүүд биднийг орхидог болохыг тайлбарла. Нөгөө хүүхдээр оймсыг буцааж тайлуул. Хүүхдүүдээс “Өршөөл нь амар амгаланг авчирдаг” гэж хэлэхийг хүс.

Ойлголтыг нь урамшуул (*судрын түүхүүдийг сонсох*): Хэдэн хоногийн өмнөөс багш эсвэл удирдагчдыг өршөөлийн тухай дараах судрын түүхүүдийн аль нэгийг нь ярихад бэлтгэхийг хүс:

1. Есүс загалмай дээр байхдаа өршөөв (Лук 23:13–34-ийг үзнэ үү).
2. Нифай ах нараа өршөөв (1 Нифай 7:6–21-ийг үзнэ үү).
3. Иосеф ах нараа өршөөв (Эхлэл 37; 41–45-ыг үзнэ үү).

Хүүхдүүдийг гурван бүлэг болгон хуваарил. Удирдагч эсвэл багш хуваалцахаар бэлтгэсэн түүхээ товчхон ярих учраас бүлэг бүрийг ангийн өөр өөр хэсэгт (“Өртөө,” *TNGC*, 179-ийг үз) хуваарилан суулга. Бүлэг болгон бүх өртөөнүүд дээр айлчилсны дараа “Хайрт Эцэг минь надад туслаач” (ХДН, 99) дууллын нэгдүгээр бадгийг дуул.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (*мэдрэмжээ хуваалцах*): Хэдэн хүүхдээс хэн нэгнийг өршөөсөн нь амар амгаланг мэдрэхэд тэдэнд тусалсан тохиолдлуудаа хуваалцахыг хүс.



Цөөн хүнтэй бүлгүүд:

Цөөн хүнтэй бүлгүүд доктор хүүхдүүдийг туршлагаа хуваалцахад урих нь илүү олон хүүхдэд хичээлд оролцох боломжийг олгодог. Хуваалцах цагт хүүхдүүд ангидаа аль хэдийн бүлгээрээ хамт суудаг. Эдгээр бүлгүүдийг цөөн хүнтэй бүлэгт үйл ажиллагаануудад ашиглаж болно. Хүүхдүүдийн оролцоо болон хүндэтгэлтэй байдлыг хангахад ангийн багш нар тусалж чадна.

Өртөөнүүд: Хэрэв танай Хүүхдийн хэсэг олон хүүхэдтэй бол хүүхдүүдийг өртөөнөөс өртөө рүү явуулахын оронд удирдагчдыг нь тэдэн дээр очуулахад анхаар.

Бид өөрсдийн Аврагч Есүс Христийг дурсан санаж, бишрэн шүтдэг

“Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй (Иохан 14:6).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд зориулан сургаалыг танин мэдэх арга замуудыг төлөвлөж, тэдгээрийг ойлгон мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Хүүхдүүд суралцахын тулд юу хийх хэрэгтэй, би Ариун Сүнсийг мэдрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдүгээр долоо хоног: Ариун ёслол бол Есүс Христийг дурсан санах үе мөн

Ойлголтыг нь урамшуул (судруудыг зургуудтай тохируулах): Дараах судрын эшлэлүүдийг самбар дээр бич: Лук 2:7; Марк 10:13, 16; Матай 26:36, 39; Иохан 19:17–18; Иохан 20:11–16. Дээрх судрууд дахь үйл явдлуудыг дүрсэлсэн зургуудыг ангийн эргэн тойронд байрлуул (СМЗН 30, 47, 56, 57, ба 59). Ариун ёслол бол Есүс Христ бидэнд хичнээн их хайртайг мөн Түүний бидний төлөө хийсэн бүхнийг дурсан санах үе мөн гэдгийг хүүхдүүдэд хэл. Эдгээр судруудаас нэгийг нь уншихыг нэг хүүхдээс хүс. Үүнтэй холбогдох зургийг сонгоод ангийн урд авчрахыг өөр нэг хүүхдээс хүс. Энэ мэтээр бусад судрууд дээр ажилла.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (ой тогтоолтыг шалгасан тоглоом тоглох): Гетсеманийн цэцэрлэг дэх Христ болон Сүүлчийн зоогийн зураг, нэг зүсэм талх, ариун ёслолын аяга ба тавиурууд, судрууд болон дууллын ном зэрэг эд зүйлсийг ширээн дээр байрлуул. Хүүхдүүдийг эдгээр зүйлс рүү хэсэгхэн зуур харахад



урь, тэгээд дараа нь эд зүйлсийг бүтээлгээр бүтээ. Бүлгээрээ ажиллаж, харсан эд зүйлсээсээ юуг нь санаж байгаага бичихийг хүүхдүүдээс хүс. Эд зүйлс болгон нь ариун ёслолын үеэр Есүс Христийг дурсан санахад хэрхэн тусалж чадахыг хүүхдүүдээр тайлбарлуул.

Хоёрдугаар долоо хоног: Есүс Христийг дурсан санах нь надад зөвийг сонгоход тусалдаг

Сургаалын тухай дуулах нь түүнээс суралцаж, санаж байхад нь хүүхдүүдэд тусалдаг. Хүүхдүүд үзүүлэнт эсвэл хөгжимт үйл ажиллагаа хийх үед илүү сайн суралцдаг. Энэ сард зориулсан санаанууд нь үүнийг хийх хэд хэдэн өөр арга замуудыг харуулдаг. Бусад хичээлүүдийг төлөвлөж байхдаа эдгээртэй төстэй санаануудыг эргэцүүлэн бод.



Сургаалыг таньж мэд (судруудыг сонсох): Хүүхдүүдийг нүдээ аньж хэрэв хүн бүхэн зөв сонголт хийдэг байсан бол амьдрал ямархуу байх байсныг төсөөлөхөд урь. Тэдний заримаас нь төсөөлсөн зүйлээ хуваалцахыг хүс. Яг ийм зүйл болсон цаг үе Мормоны Номонд гардаг тухай хүүхдүүдэд хэлээд 4 Нифай 1:15, 17-г хэн нэгэн унших үед энэ цаг үеийг хэрхэн дүрсэлснийг олж сонсохыг тэднээс хүс. Хүмүүс маш чухал нэгэн зүйлийг санаж байсан учраас зөвийг сонгох чадвартай байсныг тайлбарла. 3 Нифай 17:20–25-д өгүүлсэн үйл явдлыг дахин ярьж өг. Хүүхдүүдийг “Есүс Христийг дурсан санах нь надад зөвийг сонгоход тусалдаг” хэмээн хамтдаа хэлэхэд урь.

Ойлголтыг нь болон сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (дуунуудыг дуулах): Христ нифайчуудын хүүхдүүдийг адисалж байгаа зургийг цагаан цааснуудаар бүтээ. Есүс Христийг дурсан санахад нь туслах дуунуудыг бодож олохыг хүүхдүүдээс хүс. Эдгээр дуунуудын

заримыг нь хамтдаа дуул. Дуу бүрийн дараа нэг хүүхдээр зурган дээрээс нэг цагаан цаасыг авахуул. Бүх цаасыг авч дуусах хүртэл энэ маягаар үргэлжлүүл. Зурган дээрх хүүхдүүд Есүстэй уулзсан тэрхүү туршлагынхаа дараа хэрхэн зөв

сонголтуудыг хийсэн байж болох тухай ярилц. Тэд Есүсийг дурсан санах үедээ зөвийг сонгох болно гэдгийг хүүхдүүдэд сануул. Өдөр тутмын үйл ажиллагаандаа Есүсийг санахын тулд хийж чадах зарим зүйлсийг нэрлэхийг тэднээс хүс.

Ойлгосноо хуваалцаж:

Хүүхдүүд сайн мэдээний зарчмын талаарх ойлголтоо бусадтай хуваалцанаар Сүнсийг мэдрэх болно. Тэд сурсан зүйлээ үгээрээ, зургаараа мөн дуунуудаараа хуваалцаж чадна.

Гуравдугаар долоо хоног: Бурханы Хүү энэ дэлхий дээр мэндэлсэн

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдээс асуу: “Та нар урьд өмнө нь ямар нэгэн онцгой зүйл тохиолдохыг хүсэн хүлээж байсан уу? Энэ нь хүлээхэд удаан санагдсан уу? Эцэст нь уг зүйл тохиолдоход чамд ямар санагдсан бэ?” гэж асуу. Тэгэхэд мэдэрсэн мэдрэмжээ хуваалцах боломжийг хүүхдүүдэд олго. Адам Ева хоёрын үеэс эхлэн Тэнгэрлэг Эцэг нэгэн маш чухал үйл явдал болох болно хэмээн амласныг тайлбарла. Зөв шударга хүмүүс энэхүү үйл явдлыг тэсэн ядан хүлээж байв. Хүүхдүүдээс цөөхөн хэдэд нь “Бурханы Хүү энэ дэлхий дээр мэндэлсэн” гэж намуухнаар шивнэн хэл. Тэднээр уг өгүүлбэрийг бусад хүүхдүүдэд дамжуулж, тэгээд бүх хүүхдүүдээс үүнийг хамтдаа шивнэн хэлэхийг хүс.

Ойлголтыг нь урамшуул (түүх хуваалцах ба дуу дуулах): Хүүхдүүдээс Есүсийн төрөлтийн

тухай мэддэг зүйлсээ хуваалцахыг хүс (Лук 2:1–20-ийг үзнэ үү). Хүүхдүүдийн дурдаагүй зүйлсээр уг түүхийг гүйцээ. “Одод гялалзаж байв” (ХДН, 37) дууллыг дуулж, тэнгэр элчүүдийн дуулахыг сонсох үед хоньчдод ямар санагдсаныг төсөөлөн бодохыг хүүхдүүдээс хүс.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (Христийн Мэндэлсний баярын ил захидал хийх): Хүүхэд бүрд хуудас цаас, өнгийн болон тосон харандаануудыг өг. Цаасаа мэндчилгээний ил захидал шиг болгон нугалахад нь тэдэнд тусал. Тэднийг гэр бүлдээ зориулан Есүс Христийн төрөлтийг дээр нь зурж, Христийн Мэндэлсний баярын ил захидал хийхэд урь. Ил захидлын нүүрэн дээр “Бурханы Хүү энэ дэлхий дээр мэндэлсэн” гэж бичүүл.



Дөрөвдүгээр долоо хоног: Есүс Христ дахин ирнэ

Ойлголтыг нь урамшуул (судруудыг унших): Дараах үгсийг бичсэн цаасан туузнуудыг бэлтгэ (sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно):

Зөвхөн Тэнгэрлэг Эцэг л Есүсийн дахин ирэх _____ яг таг мэднэ (Иосеф Смит—Матай 1:40-ийг үзнэ үү).

Есүс _____ доош бууж ирнэ (Үйлс 1:11-ийг үзнэ үү).

Есүс _____ өнгийн хувцас өмссөн байх болно (С ба Г 133:48-ыг үзнэ үү).

Хуурамч Христүүд олонд _____ болно (Иосеф Смит—Матай 1:22-ыг үзнэ үү).

Ёс бусчуудыг _____ болно (С ба Г 29:9-ийг үзнэ үү).

Нар _____ болно (С ба Г 45:42-ыг үзнэ үү).

Есүс ирэх үедээ _____ илүү хурц харагдах болно (С ба Г 133:49-ийг үзнэ үү).

Есүс Христ Хоёр дахь ирэлтийнхээ дараа зөв шударга хүмүүстэй хамт _____ жил амьдрах болно (С ба Г 29:11-ийг үзнэ үү).

Хүүхдүүдийг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрд нэг эсвэл хоёр цаасан тууз өг. Тэднийг судруудаа уншиж, хоосон зайнд бичигдэх үгсийг олоход урь. Бүлэг бүрээс сурсан зүйлээ бусад хүүхдүүдтэй хуваалцахыг хүс.

Сургаалыг хэрэгжүүлэхийг урамшуул (дуулах ба хуваалцах): Бид Түүний Хоёр дахь ирэлтэд бэлтгэлтэй байхын тулд өдөр бүр Есүс Христийг дурсан санаж, шүтэн бишрэх хэрэгтэй гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс бэлтгэлтэй байхын тулд тэдний болон гэр бүлүүдийнх нь хийж чадах зарим зүйлсийг нэрлэхийг хүс. “Түүнийг дахин ирэхэд” (ХДН, 82) дууллыг дуул.

Гэрчил: Хичээлийн явцад товчхон гэрчлэл хуваалцах нь Сүнсийг урьдаг. Үнэнийг гэрчлэх үедээ “Би гэрчлэлээ хуваалцахыг хүсч байна” гэх зэрэг албан ёсны хэллэг хэрэглэх шаардлагагүй. Гэрчлэл нь “Би Есүс Христ амьдныг мэднэ” гэх мэт энгийн байж болно.



Хүүхдийн хэсэгт дуу хөгжим хэрхэн ашиглах тухай

Хүүхдийн хэсэгт дуу хөгжим ашиглахын зорилго нь Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд заах, үүний дагуу амьдрахад нь тэдэнд туслах явдал юм. Хүүхдийн хэсгийн дуунууд нь суралцах үйл явцыг илүү таатай болгож, хүүхдүүдэд сайн мэдээний үнэнийг сурч, санахад нь тусалж, Сүнсийг тэдэнтэй хамт байлгадаг.

Энэхүү тоймд санал болгосон дуунуудыг заахад тань туслах арга замуудыг жишээ болгон доор харуулав. Та эдгээр аргуудыг Хүүхдийн хэсгийн бусад дуунуудыг заахдаа ашиглаж болно. Нэмэлт санаануудыг авахын тулд өмнөх онуудын хуваалцах цагийн тоймууд дахь “Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай” хэсгийг үзнэ үү.

Нэгдүгээр сар: “Тэр Хүүгээ илгээсэн” (ХДН, 34–35)

Хүүхдүүдэд дууг сонсго. Энэхүү дуу нь хэрхэн асуултууд ба хариултуудаас бүтсэн болохыг онцол. Хүүхдүүдийн тал хэсэг нь асуултуудыг, үлдсэн хэсэг нь хариултуудыг дуулахаар хуваарил. Хэдэн удаа дуулсны дараа асуултуудыг дуулсан хэсэг хариултуудыг дуулах гэх мэтээр

эсрэгээр нь хийлгэ. Тэднийг дуугаа сайн мэддэг болох үед нь та дууг давтуулахдаа тэднийг бүлэг болгон хуваарилах олон янзын арга ашиглаарай (Жишээ нь: Охид хөвгүүдээр нь эсвэл багш хүүхдүүдээр нь гэх мэт).

Олон янзын аргуудыг ашигла: Дуунуудыг давтах олон янзын арга замуудыг бодож ол. Хүүхдүүд дууг дахин дахин дуулж мөн сонсоноор хамгийн сайн сурдаг.

Хоёрдугаар сар: “Би Бурханы төлөвлөгөөг дагана” (ХДН, 164–165)

Бурхан бидэнд нэгэн маш онцгой бэлэг өгсөн гэдгийг хүүхдүүдэд хэл. Уг дууны эхний мөрийг дуулахдаа энэ нь чухам юу болохыг олж сонсохыг хүүхдүүдээс хүс (төлөвлөгөө). Газрын зураг үзүүлээд, зүг чигээ олохын тулд газрын зургийг ашиглах нь Бурхан руу эргэн очих Түүний төлөвлөгөөг дагахтай хэр төстэй болохыг харьцуул. Энэ дуу нь бидэнд уг төлөвлөгөөний тухай зааж, бид хэрхэн Тэнгэрлэг Эцэгтэйгээ амьдрахаар буцан очиж чадахыг хэлж өгдөг

болохыг тайлбарла. Уг дуун дахь чухал зүйлсийг дүрсэлсэн зургууд (бэлэг, тэнгэр, гэр, дэлхий, төрөлт гэх мэт) болон үгсийг (төлөвлөгөө, зорилго, сонголт, чиглэл гэх мэт) өрөөний эргэн тойронд байрлуул. Та тэдэнд дууг дуулж өгөхдөө хүүхдүүдийг тэдгээр зургууд болон үгсийг цуглуулж, зөв дараалалд нь оруулуул. Зургууд болон үгс рүү хараад өөртэй чинь хамт дуулахыг хүүхдүүдээс хүс.

Гуравдугаар сар: “Би гайхширна” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 22)

Хүүхдүүдийг дөрвөн бүлэг болгон хуваа. Нэгдүгээр бүлэгт СМЗН 116-р зургийг өгөөд энэхүү дууны эхний мөрийг дуулж өг. Тэгээд үүний талаар товчхон ярилцаад, дараа нь дууг өөртэй чинь хамт хэд хэдэн удаа дуулахыг хүүхдүүдээс хүс. Бүлэг болгон дээр үүнийг үргэлжлүүлэх үедээ дараагийн бадгуудыг нь нэм (дараах зургуудыг ашигла:

хоёрдугаар бүлэг, СМЗН 108; гуравдугаар бүлэг, СМЗН 57; дөрөвдүгээр бүлэг, СМЗН 56). Бүлэг бүрийг зургуудыг нь бариулан зогсоон, хуваарилж авсан мөрүүдийг нь дуулуулах замаар эхний бадгийг бүхэлд нь дуулуул. Тэгээд бүлгүүдийг хоорондоо зургуудаа солилцож, дуугаа дахин дуулахад урь. Бүлэг болгон бүх мөрүүдийг дуулж дуусах хүртэл энэ үйл ажиллагааг давт. Дахилтыг нь дуулаад “гайхалтай” гэсэн үг хэдэн удаа давтагдаж байгааг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Дахилтыг хэд хэдэн удаа тэдэнтэй хамт давтаад “гайхалтай” гэдэг үгийг хэлэх бүрдээ гараа зүрхэн дээрээ тавихыг тэднээс хүс.




Дөрөвдүгээр сар: “Бурханы гэр бүл” (энэ тоймын 28–29-р хуудас)

Уг дуун дахь үг хэллэгүүд, хэлц үгсийг дүрсэлсэн зургуудыг зурах эсвэл олж ав (загвар зургуудыг sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно). Хүүхдүүдтэй хамт мөр бүрийг нь дуулахдаа зургуудыг нэг нэгээр нь самбар дээр байрлуул. Та нэг мөрийг нь заасны дараа зөвхөн

эхний хэсгийг дуулаад зогсож, харин үлдсэн хэсгийг нь хүүхдүүдээр дуулуулж дуусга. Дууг бүхэлд нь хэд хэдэн удаа хамтдаа дуул. Нэг эсвэл хоёр зургийг доош нь буулгахыг нэг хүүхдээс хүсээд, дууг дахин дуул. Зураг харахгүйгээр дуулж чаддаг болтол нь үүнийг давт.

Долдугаар сар: “Баптисм” (ХДН, 100–101)

Дараах үгсийг бичсэн цаасан туузуудыг бэлтгэ: Хэн, Хэзээ, Хэрхэн, Хаана. Есүс Христ баптисм хүртэж байгаа зургийг үзүүл. Зургийн хажууд “Хэн” гэж бичсэн цаасан туузыг тавь. Уг дууны эхний мөрийг дуулах үедээ Есүс хэн рүү хүрч ирснийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Хариултуудыг нь сонсоод, хүүхдүүдээр уг мөрийг өөртэйгээ хамт дуулуул. Цаасан туузууд болон дууны мөр бүхэн дээр энэ мэтээр ажилла. Эхний бадгийг бүхэлд нь хамтдаа дуул. Та олсон хариултуудынхаа нэгийг цаасан туузан дээр бичээд хүүхэд бүрд өг (Баптисм хүртээгч Иохан, өнө эрт дээр үед, усанд дүрж, Иордан гол). Хүүхдүүдийг хуваарилж авсан үгсээ дуулах үед нь босгож зогсоо. Цаасан туузуудыг хооронд нь солилцуулж, үйл ажиллагааг дахин давт.



Дадлага: Дууг үр дүнтэй заахын тулд та өөрөө дуугаа сайн мэддэг байх ёстой. Хүүхдүүдийн өмнө гараад ном руу биш тэдэн рүү харж заахын тулд гэртээ дадлага хийгээрэй.

Наймдугаар сар: “Их Эзэнийг эрэлхийл” (ХДН, 108)

Дууг нэг нэг мөрөөр нь заахдаа зургуудыг ашиглаарай (загвар зургуудыг sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно). Бүх зургуудыг самбар дээр байрлуул. Хэн нэгэн нь зургуудын нэгийг нь нууж байх хооронд нэг хүүхдийг ангиас гарахад урь. Тэгээд уг хүүхдийг ангид буцаан

оруулж, нуусан зүйлд ойртох үед нь бусад хүүхдүүдийг чангаар дуулуулж, харин холдох үед нь намуухнаар дуулуулах замаар уг хүүхдээр зургийг “эрж хайлга”. Цаг байвал үргэлжлүүлэн хий.

Энэ тоймд ашиглагдах нэмэлт дуунууд

“Есүс үнэхээр амилсан уу” (ХДН, 64)

Эхний бадгийн үгсийг самбар дээр эсвэл том хуудас цаасан дээр бич. Эхний бадгийг хүүхдүүдэд дуулж өгөөд товч ярилц. Тэгээд хамтдаа дуулж, сайн дуулж байгаа хэн нэгнээр нь тэдгээр үгсээс нэгийг нь арилгуул. Хүүхдүүдийг эхний бадгийг сурах хүртэл нь давтуулж, тэгээд дараа нь бусад бадгуудыг давт.

“Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг” (ХДН, 228–229)

Та дууг дуулахдаа хүүхдүүдийг үүнтэй танил болоход нь туслах үүднээс алгаа ташихыг тэднээс хүс. Уг дуун дахь түлхүүр үгстэй тохирох энгийн үйл хөдлөлүүдийг бодож олоход нь тэдэнд тусал. Хөгжим тоглож байх үеэр дуулалгүй зөвхөн үйл хөдлөлөө хийхийг тэднээс хүс, тэгээд дараа нь дуугаа дуулж үйл хөдлөлөө ч мөнхий. (Энэхүү дууг заахад тусалж болох зургуудыг sharingtime.lds.org хуудаснаас үзэж болно.)

“Гэр бүл үүрд хамт байх болно” (ХДН, 188)

Хүүхдүүдийг “энд бий” ба “их хайрладаг” гэх мэт олон давтагддаг аялгуутай хэсгүүдийг тодотгож, өөртэйгөө хамт дуулахад урь. “Ариун Сүмд орохын тулд бид хэзээнээс бэлтгэх ёстой вэ?” гэх

мэт энгийн асуултуудыг асуун, хүүхдүүдээр уг дууны мөрүүдээс дуулуулж, дуугаар хариулуул. Энгийн эд зүйлсийг ашиглан, гэр бүлийн гишүүдээ төлөөлж, тодорхой мөрүүдийг дуулахад нь бүлгүүдийг удирдахыг хүүхдүүдээс хүс.

“Хайр энд байна” (ХДН, 190–191)

Гэртээ ямар ямар хэлээр ярьдаг болохыг нь тэднээс асуу. Уг дууны эхний бадгийг дуулаад, бидний ярьдаг өөр нэгэн хэлийг олж сонсох үедээ гараа зүрхэн дээрээ тавихыг тэднээс хүс (хайр). Та дуулах үедээ тэдэнд сүүл холбосон болон ойлгохгүй байгаа үгсийг нь олж сонсо. Нэгдүгээр бадгийг дуулах үеэр тэдгээр үгсээ самбарт бичихийг нэг охиноос, харин хоёрдугаар бадгийн үеэр нэг хөвгүүнээс хүс. Үгсийг тайлбарлаж өгөөд тэдгээр мөрүүдийг дуул, тэгээд хүүхдүүдийг давтахад урь.

“Би тэнгэрт амьдарч байсан” (ХДН, 4)

Хүүхдүүдийг дөрвөн бүлэг болгон хувааж бүлэг тус бүрд дууны нэг нэг мөрийг хуваарилж өг. Бүлэг болгонд нэг нэг хуудас цаас тарааж өгөөд, хуваарилж авсан дууных нь мөртэй холбогдох хялбархан зураг зурахыг хүс. Зурсан зургуудыг нь үзүүлэн таниулах хэрэгсэл болгон ашиглаж уг дууг дуулаарай.



Бурханы гэр бүл

Баяр баясалтайгаар ♩ = 76-88

Үг, ая:
Matthew Neeley

1. Э - цэгт минь гэр бүл бай - даг бө-гөөд чи Би бид бүг-дээ-рээ хамт - даа түү-ний-
2. Аав - ын үү - рэг тэр - гүү - лэх мөн хан - гах Хүүх-дүү-дээ хайр-лаж тэ - дэнд сайн мэ-
3. Ээж-ийн үү - рэг бол ха - ламж-лах бэлт-гэх Хүүх-дүү-дээ өс - гэж бас хү - чир-хэг-
4. Би гэр бүл-дээ үйл-чилж, хайр - лан бас Тэ-дэнд үл - гэр жи-шээ болж амьд-рах - ыг

хүүх-дүүд
дээг заах
жүү - лэх
хүс - дэг

Гэр бүл-тэй-гээ хамт сурч бас амь - дра-хаар Энэ
Тэн-гэр-лиг Э - цэг - тээ хайр - аа үз-үүлж Аав
Гэр бүл-дээ үйл-чилж, хайр-лах - ыг мөн Дуул - гавар-
Аав ээж бо - лох тэр үе - дээ би Эд-гээр үг-

дэл - хийд тэр бид - нийг ил - гээв
гэр - тээ зал - бир - лыг удирд - даг
тай байж зал - бирах - ыг заа - даг
сийг са - нан гэр - тээ тусал - на

Тэр на - майг

© 2008 он. Маттью Нийли.

Энэхүү дууг арилжааны бус зориулалтаар сүм болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.
Энэхүү мэдэгдлийг олшруулж буй хуудас бүрт оруулна уу.

C7 F B^b F G7 C7

сaйн хүн бай - хад тус - луу - лах - аар Гэр бүл - ийг өг - сөн юм

F B^b C7 Dm B^b Gm

Тэр би - дэнд маш их хайр - тай Учир нь гэр бүл

F C7 1.2.3. F B^b F C7

Бурх - ных юм

4. F B^b F B^b F

юм



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

